**Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн**

***Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго***

Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.

***Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй***

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.4 дүгээр заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу тус яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлсэн болно. Журмын 6.2.1, 6.2.2 болон 6.7 дугаар заалтуудыг үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Эрүүл мэндийн яамны 2021 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үнэлгээг бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалаар тооцон гаргасан болно.

***Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн***

Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 165 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталсан байна. 67 болон 111-р үйл ажиллагаа давхардсан тул давхардсан ажлыг хасч, 164 үйл ажиллагааг үнэллээ.

Хүснэгт 1. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө (хугацаагаар)

| Хугацаа (улирал) | Ажлын тоо/ш | Эзлэх хувь |
|---|---|---|
| I улирал | 16 | 9.7% |
| I-II улирал | 6 | 3.6% |
| I, II улирал | 2 | 1.2% |
| II улирал | 13 | 7.9% |
| I-III улирал | 1 | 0.6% |
| II-III улирал | 7 | 4.2% |
| II, IV улирал | 1 | 0.6% |
| II-IV улирал | 3 | 1.8% |
| III улирал | 5 | 3.0% |
| III-IV улирал | 4 | 2.4% |
| IV улирал | 1 | 0.6% |
| I-IV улирал | 105 | 64.2% |
| **Нийт** | **164** | 100.0% |

Эрүүл мэндийн яамны 2021 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 164 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 91 ажил буюу нийт ажлын 55.5%-нь 100 хувийн хэрэгжилттэй; 16 ажил буюу 9.8%-нь 90 хувийн хэрэгжилттэй, 19 ажил буюу 11.6%-нь 70 хувийн хэрэгжилттэй, 14 ажил буюу 8.5%-нь 50 хувийн хэрэгжилттэй, 19 ажил буюу 11.6%-нь 30 хувийн хэрэгжилттэй, 5 ажил буюу 3%-нь 0 хувийн хэрэгжилттэй үнэлэгдлээ.

Хүснэгт 2 . Хяналт-шинжилгээний чанарын үзүүлэлт

| Үнэлгээ | Арга хэмжээ | |
|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь |
| **100 хувь** буюу бүрэн хэрэгжсэн | 91 | 55.5% |
| **90 хувь** буюу зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа | 16 | 9.8% |
| **70 хувь** буюу тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа | 19 | 11.6% |
| **50 хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн | 14 | 8.5% |
| **30 хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа | 19 | 11.6% |
| **0 хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй | 5 | 3.0% |
| Нийт | 164 | 100% |
| Дундаж | 80.1% | |

Зураг 1. Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт



Хүснэгт 2. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөний хэрэгжилт (хариуцсан нэгжээр)

| № | Үйл ажиллагааг хариуцсан нэгж | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт/үйл ажиллагааны тоо | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | |
| 1 | Бодлого төлөвлөлтийн газар | 20 | 1 | 7 | 8 | 3 | 1 | 40 |
| 2 | Санхүү, эдийн засгийн газар | 19 | 5 | 4 | | 3 | 1 | 32 |
| 3 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар | 17 | 2 | - | - | 2 | 1 | 22 |
| 4 | Төрийн захиргааны удирдлагын газар | 13 | 3 | 3 | | 1 | | 20 |
| 5 | Нийтийн эрүүл мэндийн газар | 12 | 2 | 2 | 2 | 7 | 1 | 26 |
| 6 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар | 10 | 3 | 3 | 4 | 3 | 1 | 24 |
| Нийт | | 91 | 16 | 19 | 14 | 19 | 5 | 164 |

Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ч 0-30 хувийн хэрэгжилттэй үйл ажиллагааг тус бүрд нь түүвэрлэн авч үзвэл:

**<u>Нэг. “0” хувь</u>**

1. ЗГҮАХ 2.1.3.3 Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна. Барилгын ажлын явц 30 хувьтай байна. СЭЗГ-ХОХ
2. ЗГҮАХ 2.1.10.1 Хүний эрхийн асуудлаар Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулна. Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. БТГ-СТХ
3. Нярайн сурфактант эмчилгээ үйлчилгээтэй холбоотой явцын үнэлгээ хийх, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Нярайн сурфактант эмчилгээний үр дүнг 90%-д хүргэнэ. ЭТҮГ-АЛШТХ
4. ЗГҮАХ 2.3.4.6 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгоно. Сургалтын хөтөлбөрийг сайжруулж, багш бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. НЭМГ
5. Засгийн газрын 2017 оны 112 тогтоол, “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийнэ. Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. ХШҮДАГ

Эдгээр ажлыг хариуцсан нэгжээр нь авч үзвэл Бодлого төлөвлөлтийн газар, Санхүү, эдийн засгийн газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Нийтийн эрүүл мэндийн газар, Эмнэлгийн тусламж үйлчилгээний газарт тус бүр 1 ажил хэрэгжээгүй байна.

**Хоёр. 30 хувь**

1. ЗГҮАХ 2.1.1.2 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээ хэрэгжүүлнэ. Арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ. НЭМГ-ХӨХ
2. ЗГҮАХ 2.1.5.2 Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлуулна. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж батлуулна. Хуулийн үзэл баримтлал болон хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. НЭМГ-ХӨХ
3. УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1, ЗГҮАХ 2.1.1.5 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулах. Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна. ЭТҮГ-АЛШТХ
4. ЗГҮАХ 2.1.2.1 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашгийн судалгаа хийнэ. Судалгаа хийж, тайлан гаргасан байна. ЭТҮГ-АЛШТХ
5. ЗГҮАХ 2.1.3.2 Зүрх судасны төв байгуулна. Барилгын ажлын явц 10 хувьд хүрсэн байна. СЭЗГ-ХОХ
6. Эрүүл мэндийн салбарын шилжих 26 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. Батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэн, барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулсан байна. СЭЗГ-ХОХ
7. ЗГҮАХ 2.1.5.2 Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлуулна. Хуулийн үзэл баримтлал болон хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. НЭМГ-ХӨХ
8. ЗГҮАХ 2.1.5.5, ТЭМТББ 2.4.1.9 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчилнэ. Шаардлагатай дүрэм, стандартыг шинэчлэн батлуулсан байна. БТГ-СУХ
9. ЗГҮАХ 2.1.6.2, ТЭМТББ 7.2.1.1 Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлнэ. Эрүүл мэндийн байгууллыгын 50 хувьд мэдээлэл солилцооны платформ нэвтэрсэн байна. БТГ-СТХ
10. ЗГҮАХ 2.1.9.7 Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ. Гадаад сургалтын чиглэл батлагдаж, 100-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтэн богино хугацааны гадаад сургалтанд хамрагдсан байна. БТГ-СУХ
11. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг оношилж, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 50 хувийг архаг, суурь өвчнийг илрүүлэх оношилгоонд хамруулсан байна. ЭТҮГ-АЛШТХ
12. ЗГҮАХ 2.1.14.1 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно. 60 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна. НЭМГ-УСХЗХ

13. ЗГҮАХ 2.3.1.1 Яслийн үйлчилгээ нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлнэ. Яслийн 60 бүлэгт 900 хүүхэд хамруулсан байна. НЭМГ-УСХЗХ
14. ЗГҮАХ 2.3.2.6 Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлнэ. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг баталсан байна. НЭМГ
15. ЗГҮАХ 2.3.8.5 Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлнэ. 165 багшийг мэргэшүүлсэн байна. НЭМГ
16. ЗГҮАХ 2.3.10.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлэнэ. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын хоолны газрын 20 хувийг стандартын шаардлагад нийцүүлж, өдрийн хоолны үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна. НЭМГ- УСХЗХ
17. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын эрүүл мэнд, нийгмийн халамжийн яам хоорондын Зөвлөлдөх ажлын хэсгийн ээлжит хуралдааныг зохион байгуулна. Төлөвлөгөөт арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна. ТЗУГ-ГХХ
18. Засгийн газрын 2013 оны 225 тогтоол, “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийнэ. Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. ХШҮДАГ
19. УИХ-ын 2019 оны 62 тогтоол, 1.4.г, Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
    Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, конвенцид заасан зохицуулалттай нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна. ХШҮДАГ

## ***Дөрөв. Дүгнэлт***

1. Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 80.1 хувийн үнэлгээтэй байна. Үүнээс:
    - 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн 91 үйл ажиллагаа байна.
    - 90 хувь буюу зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа 16 үйл ажиллагаа байна.
    - 70 хувь буюу тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа 19 үйл ажиллагаа байна.
    - 50 хувь буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн 14 үйл ажиллагаа байна.
    - 30 хувь буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа 19 үйл ажиллагаа байна.
    - 0 хувь буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай

холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй 5 үйл ажиллагаа байна.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахал дэгдсэнтэй холбоотой зарим үйл ажиллагааны хэрэгжих хугацааг хойшлуулсан, хэрэгжүүлээгүй байгаа ч цар тахлаас хамаарахгүйгээр хариуцсан газар, хэлтэс нь ажил үүргийн зөв зохицуулалт хийгээгүйгээс хэрэгжээгүй асуудал байна.
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь ЭМЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” - гэсэн нэг төлөвлөгөө оруулдаг ба энэ нь тусдаа төлөвлөгөө батлагдаж, жилийн турш хэрэгжүүлэн ажилладаг. Уг төлөвлөгөөнд 27 ажил тусгагдсан байна. Газар, хэлтсүүдийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг, хүний нөөцтэй нь харьцуулан үзвэл, ХШҮДАГ нь хамгийн бага хүний нөөцөөр буюу 8 орон тоотойгоор хамгийн их буюу 49 үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан бол бусад газрууд 17-19 орон тоотойгоор 21-40 ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Энэ нь нэг талаар ажлын төлөвлөлт, хүний нөөцийн бодлоготой уялдахгүй байгааг, нөгөө төлөөр ажлын байрны ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатайг харуулж байна.

**Тав. Зөвлөмж**

1. Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээний дүнгээр хэрэгжээгүй буюу хэрэгжилт хангалтгүй байгаа үйл ажиллагааг эрчимжүүлэх
2. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг 4-6 жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэл үүсч болзошгүйг анхаарах
3. Дээрх бодлогын баримт бичиг, хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг яамны болон газар хэлтсийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан эсэхэд газар хэлтсийн дарга нар хяналт тавих. Уг хяналтыг 2022 оны төлөвлөлтөд анхаарах
4. УИХ, Засгийн газраар хэлэлцүүлэх асуудлууд, ялангуяа хуулиудад нэмэлт, өөрчлөлт, шинээр боловсруулах хуулиудын явцыг эрчимжүүлж, хугацаанд нь Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэхэд анхаарах
5. Үйл ажиллагааг төлөвлөхдөө хүний нөөцтэй уялдуулан, ажлын ачааллыг жигд байхаар тооцож төлөвлөх
6. Төлөвлөгөөний хугацааг оновчтой, тодорхой болгох. Тухайн үйл ажиллагаа хэрэгжээд дуусах хугацааг тавьж байх
7. Тайлагналтыг оновчтой, шалгуур үзүүлэлтийн дагуу товч, тодорхой тайлагнаж байх

Эрүүл мэндийн яам
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР(КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| 1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээ | | | | | | | | |
| 1. | ЗГҮАХ 1.1.2.2 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зориулсан санхүүжилтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ. | Тухайн үйл ажиллагаанд зориулж батлагдсан төсөв<br><br>Бүрдүүлсэн нөөцийн хэмжээ | - | 17 долоо хоног буюу 120 өдрийн /4 сарын/ нөөцийг бүрдүүлсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-СДХ | Коронавируст халдварын цар тахлаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах хүрээнд эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх зорилгоор хөрөнгө шийдвэрлүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн 5 удаагийн шийдвэрээр 32.3 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлүүлж зарцуулсан.<br>Засгийн газрын 169 дүгээр тогтоолын дагуу “Эрдэнэс таван толгой” ХХК-аас 13,0 тэрбум төгрөгний нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлж вирусын эсрэг эм, урвалж оношлуурын зардалд зарцуулсан.<br>2021 оны төсвийн тодотголоор коронавируст халдварын эсрэг хариу арга хэмжээнд шаардлагатай төсвийг тооцож нийт 229.8 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэн батлуулж зарцуулсан. | 90.0 |
| 2. | ЗГҮАХ1.1.2.4 Сургууль, цэцэрлэгийн | Вакцинжуулалтад хамрагдалтын хувь | - | Сургууль цэцэрлэгийн хүүхдийн 80-аас | III улирал | НЭМГ-ХӨХ | Вакцин, биобэлдмэлийн төлөвлөлт, зохицуулалтын хорооны хурлыг 2021 оны 06 | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна. | | | доошгүй хувийг улирлын томуугийн вакцинжуулалтад бүрэн хамруулсан байна. | | | дугаар сарын 14-ний өдөр хуралдуулж, вакцин, биобэлдмэлийн 2021 оны худалдан авалтын товч тайлан, 2022 онд батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах вакцин, биобэлдмэл, зүү тариур, аюулгүй хайрцгийн хэрэгцээний төслийг хэлэлцсэн.<br>Энэ жилийн төсөвт 15 тэрбум төгрөг нэмэгдэж, томуугийн вакцин 300,000 тунг нэмж захиалсан.<br>2021 оны 09 сарын 10-ны өдрийн А/565 дугаар тушаалын дагуу 2-11 насны хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулсан. Улсын хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар улирлын томуугийн эсрэг вакцины хамралт 96.9%-тай байна. | |
| 3. | ЗГҮАХ1.1.2.5 Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлнэ. | Олгосон цалин, урамшуулал, дэмжлэгт зарцуулсан санхүүжилтийн хэмжээ | - | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод ажилласан эмч,ажилтнуудад илүү цагийн хөлс, урамшуулал дэмжлэг олгогдсон байна. | I-IV улирал | СЭЗГ-СДХ | Эрүүл мэндийн сайдын тушаалаар Коронавируст халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах болон бусад халдварын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ажилласан эмч, эмнэлгийн ажилтны илүү цагийн нэмэгдэл хөлсөнд 58 байгууллагад 6,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.<br>Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу Олон улсын хөл хориот халдварт өвчний голомтод болон гамшгийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн ажилтанд олгох | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэг удаагийн санхүүгийн дэмжлэгийг 92 байгууллагын 39072 эмч, эмнэлгийн ажилтанд олгож 48,4 тэрбум төгрөгийг зарцуулсан. | |
| 4. | ЗГҮАХ1.1.2.6 Олон талт хамтын ажиллагааны КОВАКС механизмын хүрээнд КОВИД-19 халдварын эсрэг вакциныг хүлээн авч, хүн амыг дархлаажуулалтад хамруулах чиглэлээр олон улсын яриа хэлэлцээ хийнэ. | Вакцинжуулалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь | ДЭМБ-ын зөвшөөрөл бүхий чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан вакциныгоруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. | Хүн амын 20 хувийг коронавирусын вакцинд хамруулсан байна. | I улирал | ТЗУГ-ГХХ | Улсын хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Ковид-19-ын эсрэг вакцины зорилтот бүлгийн 1-р тунгийн хамралт 96.1 хувь, 2-р тунгийн хамралт 91,7 хувь, 3-р тунгийн хамралт 45,2 хувь, нийт хүн амын 1-р тун 69,6 хувь, 2-р тун 66,4 хувь, 3-р тун 26,5 хувь тус тус байна. Өссөн дүнгээр 3-р тунд 862,179 хүн хамрагдсан байна. Өссөн дүнгээр 1-р тунд 6,381 жирэмсэн эмэгтэй, 7,613 хөхүүл эмэгтэй, 12-15 насны 176,349 хүүхэд, 16-17 насны 76,592 хүүхэд хамрагдаад байна. | 100.0 |
| 5. | ЗГҮАХ1.1.2.7 Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээж авна. | Засгийн газрын тогтоол | - | Монголд илэрсэн САРС-КоВ-2 /SARS-CoV-2/-ын отгуудын геномын бүтцийг тодорхойлж, молекул эпидемиологийн онцлогийг тогтоон, онош,, тандалт, сэргийлэлтийн манай орны нөхцөлд тохирсон аргачлал, зөвлөмж гаргана. Манай улсад бүртгэгдсэн шинэ | II улирал | БТГ-СТХ | Коронавируст халдварын чиглэлээр ёс зүйн зөвшөөрөл бүхий 13 судалгааны төсөл хэрэгжиж, үр дүнг нь хүлээн аваад байна. Үүнд:<br>- SARS-CoV-2-ын нутгийн омгуудын геномын бүтцийг тодорхойлж, молекул эпидемиологийн онцлогийг тогтоон, онош, тандалт, сэргийлэлтийн манай орны нөхцөлд тохирсон арга, хэрэгслэл зохион бүтээх;<br>- Хүн амын янз бүрийн давхрага, эмзэг бүлгийнхний дотор anti-CoV, anti-SARS-CoV2 IgM, IgG тархалтыг судлаж, | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн судалгаа хийсэн байна. | | | онош, тандалт, сэргийлэлт ашиглах чиглэлийг тодорхойлох;<br>- Манай оронд тохиолдож буй КОВИД-19 халдварын эмнэлзүйн илрэлийг судлаж, онцлогийг тодорхойлон эмчлэн илааршуулах оновчтой аргыг боловсруулах;<br>- Манай оронд тохиолдож буй улирлын CoV-ийн халдварын эпидемиологи, эмнэлзүйн онцлогийг судлан тогтоож, сэргийлэх, эмчлэх оновчтой арга замыг тогтоох, Вакцин хэрэглэх нас, хүрээ, дэс дараалльг тогтоож, тохиолдож болох бэрхшээлийг даван туулах аргуудыг тооцоолох;<br>- Манай орны нөхцөлд тохирсон, ДЭМБ-ын шаардлагыг хангасан оношлуур, эм, биобэлдмэл, бусад тоног төхөөрөмж, хэрэглүүр зохион бүтээж үйлдвэрлэн хангах.<br>Судалгааны нийт 40 ажлын үр дүнгийн эмхэтгэл боловсруулж гаргасан.<br>ХӨСҮТ-д SARS-CoV-2 вирүсийн хэв шинжийг тогтоох NGS шинжилгээний лаборатори байгуулж, SARS CoV-2 вирусын генийн дараалльг тогтоох тандалтыг ДЭМБ-ын стратеги зөвлөмжид тулгуурлан хийж байна.<br>КОВИД-19 халдварын судалгааны нэмэлт санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төсвийн тодотголоор КОВИД-19 халдварын судалгаанд 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. | |
| 6. | ЗГҮАХ1.1.2.8 Олон улсын байгууллагатай хамтарсан судалгааны ажлуудыг эхлүүлэх үр дүнг хүлээн авна. | Үр дүнг хүлээж авсан судалгааны тоо | - | Шинэ коронавирусын ийлдэс, тархвар зүй, насны бүлэгт суурилсан судалгаа хийсэн байна. | I-IV улирал | БТГ-СТХ | Монгол Улсад бүртгэгдсэн тохиолдлын болон хавьтлын судалгааг 2021 оны эхний хагас жилд Улаанбаатар, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Орхон, Говьсүмбэр зэрэг 5 аймагт бүртгэгдсэн дотоодын 150 тохиолдол, тэдгээрийн ойрын хавьтлыг хамруулан хийж судалгааны үр дүнг хүлээн авсан.<br>ДЭМБ-ын UNITY STUDY төслийн хүрээнд хийгдэж буй “Шинэ коронавирусын ийлдэс, тархвар зүй, насны бүлэгт суурилсан судалгаа”-г хийсэн.<br>Хүн амын дундах КОВИД-19 халдварын эсрэг ийлдсийн эсрэгбиеийн тархалтын зураглалыг судлахад 2020 оны 10-12 дугаар сарын байдлаар Монгол Улсын хүн амын дунд SARS-CoV-2-ийн эсрэг эсрэгбиеийн илэрц 1.44% түвшинд байна. Үүнийг насны бүлгээр авч үзвэл 0-4 насанд 1.38%, 5-9 насанд 0.18%,10-14 насанд 1.4%, 15-19 насанд 1.51%, 20-29 насанд 1.84%, 30-39 насанд 2.32%, 40-49 насанд 1.63%, 50-59 насанд 0.64%, 60-69 насанд 1.38%, 70-аас дээш насанд 1.01%-ийн тархалттай байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсээс эмнэлзүйн ямар нэг шинж тэмдэг илэрсэн | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өгүүлэмжтэй, эсрэгбиеийн илэрц бүхий хувь 0.41%-ийг эзэлж байсан. Судалгаанд хамрагдсан хүн амын 90.6% нь дараагийн шатны буюу 3 сарын дараах шинжилгээнд хамрагдсан ба ийлдсийн эсрэг биеийн үзүүлэлт 1.63% болж өссөн. Үүнийг насны бүлгээр авч үзвэл 0-4 насанд 1.67%, 5-9 насанд 0.52%,10-14 насанд 1.96%, 15-19 насанд 1.74%, 20-29 насанд 2.02%, 30-39 насанд 2.04%, 40-49 насанд 1.88%, 50-59 насанд 0.83%, 60-69 насанд 1.8%, 70-аас дээш насанд 2.04%-ийн тархалт бүртгэгдсэн. Эдгээр иргэдээс эмнэлзүйн шинж тэмдэг бүхий хувь урд түвшинтэй ижил буюу 0.42% эзэлж байна. Судалгааны үр дүнг “Монгол Улс дахь SARS-CoV-2 вирүсийн эсрэг биеийн тархалт: хүн ам, насны бүлэгт суурилсан судалгаа” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллүүдийг салбартаа тэргүүлэх олон улсын, нэр хүнд бүхий the Lancet Regional Health–Western Pacific сэтгүүлд нийтлэгдсэн | |
| 7. | ЗГҮАХ1.1.3.2 Шаардлагатай аймгуудад ЗӨСТ, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна. | Байгуулсан ЗӨСТ болон хил дагуух боомтод байгуулсан тандалтын нэгжийн тоо | - | Хил дагуух 4 боомтод тандалтын нэгж байгуулж, нэг аймагт ЗӨСТ байгуулсан байна. | I-IV улирал | НЭМГ-ХӨХ | Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймагт Зоонозын өвчин судлалын төв байгуулах талаар үндэслэл, танилцуулга, шаардагдах төсвийн төслийг хийсэн.<br>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хилийн нэвтрэх цэгийн тандалтыг сайжруулах үүднээс Өмнөговь аймгийн | 50.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хадны нутаг дэвсгэрт орших “Гашуун сухайт” хилийн боомтод нүүрс экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагын жолооч, ажилчдын молекул биологийн шинжилгээ хийх, тохиолдлын тандалт судалгаа хийх зорилгоор 2021 оны 9 сарын 26-наас ХӨСҮТ-ийн баг томилогдон 14 хоногийн давтамжтой солигдон ажиллаж байна.<br>SARS-Cov-2 вирусийн Омикрон хувилбар бүртгэгдсэнтэй холбоотой хилийн нэвтрэх цэгийн хяналтыг сайжруулахаар Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/734 дүгээр тушаалыг батлуулсан. ЭМЯ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-ээс Чингис хаан ОУНОБ, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Увс аймгийн Боршоо, Дорнод аймгийн Эрээнцав, Баянхошуу боомтод мэргэжлийн баг ажиллаж, бэлэн байдалтай танилцан, дэмжлэгт хяналт хийсэн. | |
| 8. | ЗГҮАХ1.1.3.3<br>Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | Мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо | - | Төлөвлөгөөт сургалт сурталчилгаа бүрэн хийгдсэн байна. | I-IV улирал | НЭМГ-ХӨХ, УСХЗХ | Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх чиглэлээр 217 төрлийн инфографик, 109 удаагийн мэргэжлийн эмчийн зөвлөмж, 124 видео шторк, 46 төрлийн зөвлөмж (текст) бэлтгэн Эрүүл мэндийн яамны фэйсбүүк хуудсанд байршуулан давхардсан тоогоор 76,998,256 иргэдэд мэдээлэл хүргэж, | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 201,056 гаруй хүн хуваалцсан байна.<br>Коронавируст халдвар (COVID-19)-ын Монгол Улсын нөхцөл байдлын мэдээний загварыг шинэчилж, өдөр бүр постерыг нийт 296 удаа бэлтгэн нийтэлсэн. Коронавируст халдварын нөхцөл байдлын хэвлэлийн хурлыг 249 удаа зохион байгуулж Эрүүл мэндийн яамны фейсбүүк хаягаар шууд (Live) дамжуулахад давхардсан тоогоорр 46,259,026 хүн хандалт хийж, 29,256 хүн мэдээллийг хуваалцсан байна.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтыг эрчимжүүлэх төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдаар батлуулан хэрэгжүүлж байна. | |
| 9. | ЗГҮАХ1.1.3.4 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинээр барьж, ашиглалтад оруулна. | Батлагдсан ТЭЗҮ | - | Барилгын ТЭЗҮ боловсруулж, батлуулсан байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | АХБ-ны “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийн яаралтай тусламжийн зээлийн санхүүжилтээр ЗӨСҮТ-ийн дэргэд онцгой байдлын үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын байрыг 2021 оны 12 дугаар сарын 01-нд барьж дуусгасан. (7.3 тэрбум төгрөг). Улсын комисст 2022 оны 03 дугаар сарын 10-нд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 100.0 |
| 10. | ЗГҮАХ1.1.3.6 Шинэ коронавирусын халдварыг тодорхойлох оношлуурыг | Бүтээн, туршсан оношлуур | - | Оношлуурын бүрдлийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | I-IV улирал | БТГ-СУХ | Эрүүл мэндийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн хурлаар “Шинэ төрлийн SARS CoV2 -ын вирусийн эсрэг бие илрүүлэх оношлуур” гарган | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дотооддоо бүтээн туршиж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | | | | | | авах төслийн хүрээнд гарган авсан оношлуурыг бүртгэж гэрчилгээ олгосон.<br>2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр "SARS-COV-2-ыг шүлсэнд илрүүлэх шинэ ПГУ оношлуур бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх" судалгааны ажлын хүрээнд бүтээгдсэн оношлуурыг бүртгэн гэрчилгээ олгосон. Энэхүү оношлуурыг 2021 оны 03 дугаар сараас оношилгоонд нэвтрүүлж, 1.3 тэрбум төгрөгийн 200 мянган ширхэг оношлуурыг худалдан авч, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>"CHOROS SARS-CoV-2 RT-qPCR илрүүлэх цомог оношлуурын судалгаа, туршилт"-аар "Чорос-Онош" ХХК-ны зохион бүтээсэн оношлуурыг бүртгэсэн. | |
| 11. | ЗГҮАХ1.1.3.7<br>ТЭМТББ 5.4.1.2<br>Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн молекул биологийн лабораторийн чадавхийг бэхжүүлнэ. | Чадавхийг бэхжүүлсэн лабораторийн тоо | - | 5 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-д БХ-ПГУ төхөөрөмжтэй болж, лабораторийн чадавхи нэмэгдсэн байна. | I-IV улирал | ЭТҮГ-ЭТЧАБХ | 2021 эхний хагас жилд Улаанбаатар хотод 13, орон нутагт 12, нийт 25 молекул биологийн лабораторийг шинээр байгуулан, ПГУ шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлсэн. Үүнд: УНТЭ, УХТЭ, ЭХЭМҮТ, ЦТЭ, АШУҮИС болон БГД, СХД, ЧД, СБД, БЗД, БН, ХУД, НД-ийн ЭМТ, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Хэнтий, Завхан аймгуудын Нэгдсэн эмнэлэг, Өвөрхангай, Өмнөговь аймгийн БОЭТ, Өмнөговь аймгийн Цагаан хад боомт дахь лабораториуд хамаарна.<br>Мөн ХӨСҮТ-ийн Вирус судлалын | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | лаборатори, ЗӨСҮТ, Дархан-Уул, Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн лабораторит PCR аппарат, нуклейн хүчил ялгагч аппаратыг шинээр нэмж суурилуулан, хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Яамнаас эхний хагас жилийн хугацаанд молекул биологийн лабораториудад шаардлагатай оношлуур, дагалдах хэрэгслээр тасралтгүй ханган ажилласан.<br>2021 оны 1 дүгээр сард 80 лабораторийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ, УНТЭ, УХТЭ-ийн лабораторид 14 хоногоос 2 сарын хугацаатай дагалдуулан сургаж бэлтгэсэн. | |
| 12. | ЗГҮАХ1.1.4.1 Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтыг шинэчлэн боловсруулна. | Шинэчлэн батлагдсан жагсаалт | - | Шинэчилсэн жагсаалтын дагуу татвараас чөлөөлөгдөж,хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | I-IV улирал | ЭТҮГ-ЭТЧАБХ НЭМГ-УСХЗХ | Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар “Коронавируст халдвар (COVID-2019)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, жагсаалтад “Ремдесивир” тарилгын уусмалын БТКУС код “3004.90.10”-ыг нэмэлтээр оруулах” асуудлыг хэлэлцүүлэн, 274 дүгээр тогтоолоор баталгаажуулсан.<br>Мөн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар “Коронавируст | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | халдвар (COVID-2019)-ын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, жагсаалтад 4 нэрийн вирүсийн эсрэг эм (тоцилизумаб, касиривимаб, молнупиравир, паксловид)-ийг оруулж батлуулсан. | |
| 13. | ЗГҮАХ1.1.15.1 Эрүүл мэндийн судалгаанд үндэслэн багш, суралцагчийн хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн зохицуулалт хийнэ. | Холбогдох чиглэлээр гарсан шийдвэрийн тоо | - | Багш, ажилтан, суралцагчийн өвчлөлийн мэдээлэлд үндэслэн хичээл таслалт, хоцролт, завсардалтын шалтгааныг тодорхойлсон байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Боловсролын салбарын багш, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх насны багцын үзлэг оношилгооны дүн 2021 оны 2 дугаар сард гарсан. Үзлэг, оншилгоонд хамрагдсан багш ажилтны 80.9% нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багцад бүрэн хамрагдсан. Эрүүл мэндийн эрсдэлд суурилсан хичээл таслалт, хоцролт, завсардалтын шалтгааныг тодорхойлоход БШУЯ-тай хамтран ажиллах саналыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 09 дүгээр сарын 1а/5181 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 70.0 |
| 14. | ЗГҮАХ 1.1.3.1 КОВИД-19 цар тахлын халдвартай тэмцэх хариу арга хэмжээнд олон улсын дэмжлэг, туслалцаа авах, эм, эмнэлгийн болон хувийн хамгаалах | Бүрдүүлсэн нөөцийн хэмжээ | - | Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн бэлэн байдлын нөөц нэмэгдсэн байна. | I-IV улирал | ТЗУГ-ГХХ | Энэ хүрээнд дараах ажлыг гүйцэтгэсэн:<br>2021 оны 1-р сарын 4-ний өдөр АНУ-ын Элчин сайдын яаманд хандаж хүсэлт гаргасны үр дүнд 450,000 ам. долларын /1,2 тэрбум төг/ үнэ бүхий дараах нөөцийг буцалтгүй тусламжаар хүлээн авч, хуваарилсан: | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлнэ. | | | | | | • 30,000 ширхэг STANDARD Q COVID-19 Ag Test (SD Biosensor)<br>• 24,000 ширхэг нүүрний хамгаалалт<br>• 85,000 ширхэг N95 амны хаалт<br>• 3,150 хайрцаг бээлий.<br>2021 оны 2 дугаар сард БНФУ-аас 54,000 евро буюу 184 сая төгрөгийн үнэ бүхий хүчилтөрөгчийн хангамжийн хэрэгслүүдийг хүлээн авч ГССҮТ-д олгосон.<br>Дэлхийн банкинд хандаж хүсэлт гаргаснаар 1 сая ам.доллар буюу 2,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгслийг буцалтгүй тусламжаар хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>2021 оны 4 дүгээр сард БНХАУ-ын Элчин сайдын яаманд хандаж дэмжлэг хүссэний дагуу 2021 оны 5 дугаар сард 2,6 тэрбум төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгсэл болон PCR оношлуурыг хүлээн авсан.<br>ХБНГУ-ын Холбооны Эрүүл мэндийн яамнаас 145,068 ам.доллар буюу 413 сая гаруй төгрөгийн үнэ бүхий 462,000 ширхэг мэс заслын амны хаалтыг 5 дугаар сард хүлээн авсан.<br>Швейцарын Холбооны Улсаас 657,891.35 швейцар франк буюу 2 тэрбум 300 сая төгрөгийн үнэ бүхий 45 ширхэг хүчилтөрөгч өтгөрүүлэгч, зөөврийн 40 ширхэг амьсгалын аппарат, дагалдах хэрэгслийг 7 дугаар сарын 12-ны | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдөр хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан. Мөн 9 дүгээр сард 500 сая төгрөгийн өртөг бүхий 4 ширхэг хөдөлгөөнт рентген аппарат, 12 дугаар сард 677 сая төгрөгийн өртөг бүхий 6 ширхэг хөдөлгөөнт дижитал рентген аппаратыг хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудад олгосон<br>Зүүн хойд Азийн эрүүл мэндийн аюулгүй байдлын механизмын хүрээнд БНСУ-ын Засгийн газраас 279,046.99 ам доллар буюу 600,000,000 сая төгрөгийн үнэ бүхий STANDARD Q COVID-19 Ag Test (SD Biosensor) түргэвчилсэн оношлуурыг хүлээн авсан.<br>КОВИД-19 халдвартай тэмцэх эм, эмчилгээний тоног төхөөрөмж, хэрэгслийн хангамжийг дэмжих ACT-A SFF" механизмын санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн Сангаас 858,612 ам.доллар буюу 2 тэрбум 445 сая төгрөгийн өртөг бүхий эм, хүчилтөрөгчийн хангамж хэрэгсэл болон хувийн хамгаалах хэрэгслийг 2021 оны 7-9 дүгээр саруудад хүлээн авч 21 аймаг, нийслэлийн эмнэлгүүдэд хуваарилсан.<br>БНХАУ-ын ГХЯ-ны буцалтгүй тусламжийн 5 сая юанийн санхүүжилтээс 736,867,720 төгрөгийн үнэ бүхий ПГУ оношлуур, урвалж бодисыг 2021 оны 11 дүгээр сард хүлээн авсан. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үлдсэн санхүүжилтээр өндөр эрсдэлтэй тоног төхөөрөмж авахаар захиалга өгсөн байгаа. Япон Улсын Засгийн газраас 883,000,000 иен буюу 22.9 тэрбум төгрөгийн яаралтай тусламж үзүүлэх Ойлголцлын бичиг баримтад 8 дугаар сард Эрүүл мэндийн сайд болон ЖАЙКА-ийн Суурин төлөөлөгч нар гарын үсэг зурж, эхний ээлжинд 21.000 ширхэг түргэвчилсэн оношлуурыг 2021 оны 12 дугаар сард хүлээн авсан. | |
| 15. | Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр эрүүл мэндийн байгууллагуудыг орчин үеийн эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангана. | Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо | - | Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна. | I-IV улирал | ТЗУГ-ГХХ | Япон Улсын Засгийн газрын 1 тэрбум иенийн буцалтгүй тусламжийн 632,8 сая иен буюу 16,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд болон төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд тоног төхөөрөмжийн хангалт хийж эхэлсэн:<br>- 2021 оны 8 дугаар сард 10 ширхэг цусны хийн анализатор,<br>- 11 дүгээр сард 50 ширхэг судас тодруулагчийг хүлээн авч хуваарилан, сургалтыг зохион байгуулсан.<br>- Үлдсэн тоног төхөөрөмж болох 10 ширхэг унтуулгын аппарат, 1 ширхэг автоклав, 12 ширхэг C-Arm хөдөлгөөнт рентген, 2 ширхэг Barocamera, уушгины мэс заслын иж бүрдлүүд, уушгины дуран, түргэн тусламжийн автомашин зэрэг нь 2022 оны 1 дүгээр улиралд хилээр орж ирэхээр байна. | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Швейцарын Холбооны Улсаас 657,891.35 швейцар франк буюу 2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 45 ширхэг хүчилтөрөгч өтгөрүүлэгч, зөөврийн 40 ширхэг амьсгалын аппарат, 500 сая төгрөгийн өртөг бүхий 4 ширхэг хөдөлгөөнт рентген аппаратыг 7-9 дүгээр саруудад хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан. Мөн 1.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 10 ширхэг хөдөлгөөнт дижитал рентген аппаратыг хүлээн авч 7 аймгийн нэгдсэн эмнэлэг, Өргөө амаржих газар болон ЭНЭҮТ-д хүлээлгэн өгсөн.<br>КОВИД-19 халдвартай тэмцэх эм, эмчилгээний тоног төхөөрөмж, хэрэгслийн хангамжийг дэмжих ACT-A SFF" механизмын санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн Сангаас Монгол Улсад 858,612 ам.доллар буюу 2.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийг 2021 оны 7-9 дүгээр саруудад хүлээн авч 21 аймаг, нийслэл дэх эмнэлгүүдэд хуваарилсан. | |
| 16. | Олон улсын банк санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулж батлуулна. | Батлагдаж хэрэгжсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ | - | Олон улсын банк санхүүгийн байгууллагын санхүүжилтээр төсөл хэрэгжсэн байна. | I-IV улирал | ТЗУГ-ГХХ | КОВИД-19 халдвараас сэргийлэх вакцины санхүүжилт 2021 оны улсын төсөвт батлагдаагүй тул санхүүжилтийн эх үүсвэрийг олон улсын банк санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр шийдвэрлэх зорилгоор дараах ажлыг 2021 онд гүйцэтгэсэн: | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Дэлхийн банкны санхүүжилттэй “КОВИД-19 халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах” төсөл дээр Нэмэлт зээлийн хэлэлцээр байгуулж, 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар зээлийн хэлэлцээг соёрхон батлуулах тухай хуулийг баталсан.<br>- АХБ-ны APVAX хөтөлбөрийн хүрээнд вакцин худалдан авах нэмэлт санхүүжилтийн 40 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээг 6 дугаар сарын 7-ны өдөр эцэслэсэн. Зээлийн хөрөнгөөр 2021 оны 3-5 дугаар саруудад худалдан авч хүн амыг вакцинжуулсан КОВИД-19 халдварын эсрэг вакцины төлбөрийг нөхөн санхүүжүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>- Дээрх зээлийн 21 сая ам. доллар нь Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкнаас гарах ба уг Зээлийн хэлэлцээрийг 2021 оны 10 дугаар сарын 7-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон баталсан. Уг зээлийн хөрөнгөөр 2021 оны 3-5 дугаар саруудад худалдан авч хүн амыг вакцинжуулсан КОВИД-19 халдварын эсрэг Пфайзер, Синофарм үйлдвэрлэгчдийн вакцины төлбөрийг 2021 оны 9-12 дугаар саруудад нөхөн санхүүжүүлсэн. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| 2.1. Эрүүл мэнд, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | | |
| 17. | ЗГҮАХ 2.1.1.1 "Эрүүл, идэвхитэй амьдрал" арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Батлагдсан шийдвэр | - | Арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна. | I-IV улирал | НЭМГ-ХБӨХ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаалаар “Эрүүл идэвхтэй амьдрал” 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. | 100.0 |
| 18. | ЗГҮАХ 2.1.1.2 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээ хэрэгжүүлнэ | Батлагдсан шийдвэр | - | Арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ. | I-IV улирал | НЭМГ-ХӨХ | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (2017-2020)-ийн үнэлгээ хийх, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/635 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.<br>Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж, халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, төлөвлөгөөний биелэлтийг гаргасан. | 30.0 |
| 19. | ЗГҮАХ 2.1.1.3 "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Батлагдсан шийдвэр | - | Арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ. | I-IV улирал | НЭМГ-ХБӨХ | "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 12 дугаар сарын 09-ний өдрийн А/760 дугаар тушаалаар батлуулсан. | 70.0 |
| 20. | ЗГҮАХ 2.1.1.4<br><br>“Хавдрын эсрэг” арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хувь | 30 хувь | Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралтыг 40 хувьд хүргэнэ. | I-IV улирал | НЭМГ-ХБӨХ | “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын А/360 дугаар тушаалаар батлуулсан.<br>Мөн Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/201 дүгээр тушаалаар хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээ, хяналтыг сайжруулах | 70.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 56,827 эмэгтэй хамрагдаж, зорилтот насны эмэгтэйчүүдийн эрт илрүүлэгт хамрагдалт 22.7 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.8 байснаас 22.7 хувь хүрсэн өссөн үзүүлэлттэй байна. | |
| 21. | УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1, ЗГҮАХ 2.1.1.5 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулах | Засгийн газрын тогтоол | “Элэг бүтэн Монгол” эхний хөтөлбөр хэрэгжиж дууссан. | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна | I-II улирал | ЭТҮГ-АЛШТХ | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын А/629 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна. | 30.0 |
| 22. | ЗГҮАХ 2.1.1.6 “Харшлаас сэргийлэх” үндэсний хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулах | Засгийн газрын тогтоол | - | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн байна. | II улирал | НЭМГ-ХБӨХ | "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/785 тоот тушаалаар батлуулсан. | 90.0 |
| 23. | ЗГҮАХ 2.1.1.7 “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Засгийн газрын тогтоол | - | Арга хэмжээний төлөвлөгөө Засгийн газрын тогтоолоор батлагдсан байна. | II улирал | НЭМГ-ХБӨХ | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын А/559 дугаар тушаалаар батлуулсан. | 100.0 |
| 24. | ЗГҮАХ 2.1.2.1 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашгийн судалгаа хийнэ. | Судалгааны тайлан | - | Судалгаа хийж, тайлан гаргасан байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашгийн судалгаа хийх ажлын хүрээд ДЭМБ-тай 3 удаа уулзалт зохион байгуулсан. Мөн Булган, Орхон аймаг, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт вируст гепатитын | 30.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмнэлгийн тусламж, үйлчилгээний үр нөлөөллийн судалгаа, үнэлгээг зохион байгуулав.<br>Судалгааны хүрээнд цуглуулсан тоо баримтад дүн шинжилгээг хийх ажил хийгдэж байна. | |
| 99. | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийн тайланг Засгийн газарт хүргүүлнэ. | Засгийн газарт хүргүүлэх | Хэрэгжилтийн эхний тайланг 2020 онд Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. | Хэрэгжилтийн 2 дахь жилийн тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна. | I-IIулирал | БТГ-СУХ | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийн тайланг бусад 2020 оны байдлаар нэгтгэж, 1а/2866 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хөтөлбөрийн 2020 оны жилийн эцсийн байдлаарх хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг бусад үндэсний хөтөлбөрүүдийн тайлангийн хамт Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, танилцуулсан | 100.0 |
| 100. | ЗГҮАХ 2.1.9.6 Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Бэлтгэгдсэн, чиглүүлэгч, сувилагч-сургагч багшийн тоо 112 | Сургалтыг удирдах сувилагч-сургагч багш 100-аас доошгүй бэлтгэгдсэн байна. | I-IV улирал | БТГ-СУХ | “Төгсөлтийн дараах сургалт удирдах “Сувилахуйн чиглүүлэгч багш”, “Сувилахуйн сургагч багш” бэлтгэх сургалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/488 дугаар | 70.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалаар батлуулсан. ЖАЙКА-тай хамтарсан тус ажлын хэсэг нийт 7 удаа хуралдаж, “Монголын сувилахуйн мөн чанар – Монголын сувилахуйн ирээдүй” сургалт семинарыг 2021 оны 9 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд, “Сувилахуйн сургагч, чиглүүлэгч багшийн хөтөлбөр шинэчлэх” семинарыг 2021 оны 11 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан ба сувилахуйн сургагч багшийн сургалтыг 2021.11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 46 сувилахуйн сургагч багш бэлтгэсэн. Сувилахуйн сургагч багшийн дараагийн сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 27-29-ны өдрүдэд зохион байгуулж 24 сургагч багш, чиглүүлэгч багшийн сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулж 24 чиглүүлэгч багш сургахаар тус тус бэлтгэл ажлыг хангасан. | |
| 101. | ЗГҮАХ 2.1.9.7 Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ. | Батлагдсан тэргүүлэх чиглэл | - | Гадаад сургалтын чиглэл батлагдаж, 100-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтэн богино хугацааны гадаад сургалтанд хамрагдсан байна. | I-IV улирал | БТГ-СУХ | 2022-2024 оны гадаад сургалтын тэргүүлэх чиглэлийг батлах Эрүүл мэндийн сайдын тушаалын төсөл боловсруулж, санал авахаар ажиллаж байна.<br>ХӨСҮТ-ийн Вирүс судлалын лабораторийн 3 мэргэжилтэн Япон Улсын ХӨҮХ-д 14 хоног суралцаж шинжилгээ хийх протокол, дата боловсруулах арга технологид суралцаад ирсэн. | 30.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 102. | ТЭМТББ 3.1.2.1 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх төлөвлөлтийг тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан, олон улсын стандартад нийцүүлэн хийнэ. | Хүнийнөөцийн 2026 он хүртэлх батлагдсан тооцоо, төлөвлөлт | Өмнө гаргасан хүний нөөцийн урт хугацааны тооцоо, төлөвлөлт 2020 онд дуусгавар болсон. | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх тооцоо, төлөвлөлт хийгдсэн байна. | I-IV улирал | БТГ-СУХ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/375 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх төлөвлөлт хийх ажлын хэсгээс их эмч, сувилагчийн хэтийн төлөв, тооцоог хүн ам зүй, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурлан хийсэн.<br>Тусламж, үйлчилгээний ашиглалт, амбулатори, стационарын үзлэгийн тоотой уялдуулж эмч, сувилагчийн 2026 он хүртэлх зорилтот тоог үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн чиглэл тус бүрээр нэмэлтээр тооцож гаргаж байгаа бөгөөд үр дүнг 2022 оны 02-03 дугаар сард яамны Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулахаар БТГ-ын СУХ-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. | 70.0 |
| 103. | Сувилагч мэргэжлээр суралцагчийн тоог 2021-2022 онд нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлнэ. | Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2019-2020 онд 1:2 арга хэмжээг хэрэгжүүлсэн. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | I-IV улирал | БТГ-СУХ | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албатай санал солилцсоны үндсэн дээр нийт 9 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТЗУГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлсэн. 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллав. Үүнд:<br>1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, | 90.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | АШУҮИС-тай 2021 оны 04, 05 дугаар сард уулзалт зохион байгуулж, туслах сувилагчийн сургалтын хугацаа, төрлийн талаар санал солилцож зөвшилцсөн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад туслах сувилагчийн сургалтын талаар 1а/2724, туслах сувилагч, шүдний эмчийн туслах, ариутгагч, эмгэг судлалын туслах ажилтны сургалтын талаар 1а/3442 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн. АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, ЭМХТ-тэй хамтран “Туслах сувилагч” бэлтгэх 3 сарын сургалтын хөтөлбөр боловсруулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга, Сувилахуйн салбар зөвлөлийн даргаар батлуулав.<br>2. Коронавируст халдварын тусламж, үйлчилгээнд дайчлан ажиллуулах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг шуурхай зохион байгуулахтай холбогдуулан сувилахуйн хөтөлбөрөөр сургалт эрхэлдэг төр, хувийн хэвшлийн их, дээд сургуулийн удирдлагуудтай цахим уулзалт 2021 оны 5 дугаар сард зохион байгуулж, төгсөх дамжааны оюутнуудын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, зөвшөөрлийн шалгалтыг хамтран зохион байгуулсан. Зөвшөөрлийн шалгалтад тэнцэж, зөвшөөрлийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гэрчилгээ авсан, дайчлан ажиллуулах боломжтой сувилагч нарын судалгааг 21 аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлсэн.<br>3. Сувилагчийн төгсөлтийн дараах сургалтын чиглэл, индексийг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 07-ны А/445 дугаар тушаалаар батлуулсан. Шинэчлэн батлагдсан сургалтын чиглэл, индексийг 2/3823 тоот албан бичгээр ЭМХТ, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг холбоо, анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуульд хүргүүлсэн.<br>4. Сувилагчийн карьерийн бичиг баримт боловсруулах ажлын хэсгийн хурлыг нийт 5 удаа зохион байгуулж, баримт бичгийн төслийг сайжруулах ажлыг зохион байгуулав.<br>5. “Мэргэшсэн сувилагчийн хүний нөөцийн өнөөгийн байдлыг тодорхойлох нь” судалгааны арга аргачлал, төслийг АШУҮИС-ийн Эрдмийн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хэлэлцүүлж, батлуулсан.<br>6. Төгсөлтийн дараах сургалт удирдах “Сувилахуйн чиглүүлэгч багш”, “Сувилахуйн сургагч багш” бэлтгэх сургалт | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн удирдамжийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/488 дугаар тушаалаар батлуулав. Ажлын хэсэг 7 удаа хуралдаж, төлөвлөгөөний дагуу ажилласан бөгөөд сувилахуйн сургагч багшийн сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 64 сувилахуйн сургагч багш бэлтгэсэн. Сургагч багшийн сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 27-29, чиглүүлэгч багшийн сургалтыг 12 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.<br>7. “Олон улсын сувилагчдын өдөр”-т зориулсан телевизийн нэвтрүүлэгт ЭМЯ, Монголын сувилагчдын нийгэмлэг, ЖАЙКА-ийн төслийн төлөөлөл 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдөр оролцож, сувилахуйн тусламж үйлчилгээний ач холбогдол, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар танилцуулав. | |
| 104. | Эрүүл мэндийн ажилтнуудын дархлааг дэмжих, витаминжуулалтад хамруулна. | Дархлаа дэмжих, витаминжуулалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо | - | Эрүүл мэндийн ажилтны дархлааг дэмжиж, витаминжуулалтад хамруулсан байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Эрүүл мэндийн ажилтны дархлааг дэмжиж, витаминжуулалтад хамруулах ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудад дараах үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Үүнд<br>Халдварт өвчин судлалын | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үндэсний төв: Цахиур төмөр ХХК-аас 3 нэр төрлийн 25 сая төгрөгний үнэ бүхий бүтээгдэхүүнийг 758 ажилчидад олгосон байна.<br>Арьсны өвчин судлалын үндэсний төв: Коронавирусын халдвартай өвчтнүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хэвтэн эмчлэх тасагт ажилласан эмнэлзүйн багийн эмч, эмнэлгийн нийт 35 ажилчдад болон тус халдвараар өвдсөн нийт 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 1,803,750 төгрөгийн дархлаажуулах багцийг олгосон. “IVCO” LLC компанитай хамтран ажилчдын ясны сийрэгжилтийг үнэгүй тодорхойлж, өндөр тунтай витамин Д хөнгөлөлттэй үнээр нийлүүлж дэмжлэг үзүүлсэн.<br>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв: Ерөнхий захирлын 2019 оны А/46 дугаар тушаалаар өдөрт 0,5 кг аарц буяу сүү, сүүн бүтээгдэхүүн олгож байна.<br>Улсын гуравдугаар төв эмнэлэг: Халдварт өртсөн 198 ажилтнуудаа тасаг нэгжүүд дархлаажуулах бэлдмэл болон нийт 8,1 сая төгрөгийн мөнгөн тусламжийг үзүүлсэн. Дархлаа дэмжих зорилгоор Кронавирусын цар тахлын голомтод ажиллаж буй эмч сувилагч үйлчлэгч нийт 300 эмч ажилчдад зөв аарцны ундаа,чихрийн багцаар үйлчилсэн. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зоонозын өвчн судлалын үндэсний төв: Коронавирусt цар тахлаас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор эмч, эмнэлгийн ажилчдад чацаргана, аарц, тамедин, санитол, салимон, витамин С зэрэг 2,200,000 төгрөгийг өөрийн урсгал төсвөөс болон хандив тусламжаар олгосон ба үйлдвэрчний эвлэлийн хорооноос сар уух биологийн нэмэлт бүтээгдэхүүнээр хангаж ажилласан байна.<br>Улсын нэгдүгээр төв эмнэлэг: Эмнэлгийн гамшгийн шуурхай штабын шийдвэрийн дагуу цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллаж буй эмнэлгийн нийт ажилтны дархлааг дэмжих зорилгоор өглөө бүр эмнэлгийн захиргаанаас халуун аарц, дархлаа дэмжих витаминуудыг тараасан байна.<br>Ховд аймгийн БОЭТ: Захирлын тушаалаар эмнэлгийн ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар төлөвлөгөө, хөтөлбөр гарган нийт 438 ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж үзлэгээр хамгийн өндөр үзүүлэлттэй гарч ирсэн витамин Д-ийн дутагдлыг нөхөх зорилгоор 435 ажилчдад 1 сар уух витамин Д олгож 2,560,000 төгрөгийг байгууллагаас зарцуулсан байна.<br>Хавдар судлалын үндэсний төв:. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Enica organic impex - Коронавируст халдвар цар тахлын хүнд нөхцөлд албан үүргээ нэр хүндтэй гүйцэтгэж байгаа тус төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудад 50 сая төгрөгийн үнэ бүхий 11 төрлийн олон улсын стандарт хангасан хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг хандивласан.<br>Цус сэлбэлт судлалын үндэсний төв: Ерөнхий захирлын тушаалаар 2020 оны 01 дүгээр сарын 07-ны А/06, 2021 оны 01 дүгээр сарын 08-ны А/02 тушаалаар ажилтнуудын дархлааг дэмжих зорилгоор 1,050,000 төгрөгний үнэ бүхий халуун аарцаар тогтмол үйлчилж байна. Мөн витамин С олгоход 977,200 төгрөг, витамин Д олгоход 477,200 төгрөгийг үйлдвэрчний эвлэлийн хорооноос хамтран байгууллагын нийт ажилтанд олгосон байна.<br>Эрүүл мэндийн хөгжлийн төв:<br>Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих, халдвар хамгааллын дэглэмийг баримтлахад дэмжлэг үзүүлж сар бүр байгууллагын нийт албан хаагчид болон Дуудлага зохицуулах албаны ажилтнуудад маск, бээлий, хамгаалах хэрэгслээр хангадаг. Тайлант хугацаанд нийт 84,000 ширхэг нэг удаагийн маск, 2,675 ширхэг N95 маск, 480 хайрцаг бээлий, 100 ширхэг дезинол, 210 ширхэг | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санитол, 81 ширхэг гар ариутгах салфетка, Хунчир 3.1 кг, 100 ширхэг аньс чацарганы цэвэр жүүс, Норов-7 тан 600 хайрцаг, Мана-4 тан 600 хайрцгийг түгээж буцалган өглөө. Мөн хүйтний улиралд халуун аарцыг тогтмол буцалган өгч байна. Халдвараас сэргийлэх, дархлаа дэмжих зорилгоор Enica organic Impex ХХК-аас ирүүлсэн үр жимсний тос бүхий найрлагатай 11 төрлийн хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болон витамин C, D, аспирин-100 эмний сарын хэрэглээг бүх албан хаагчдад олгосон байна.<br>Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв: Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор чацаргана, витамин C, олон найрлагат витамин зэрэгт нийт 87,354,000 санхүүжилт зарцуулан эмч ажилчидад түгээн ажилласан байна.<br>Эрүүл мэндийн яам: Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/188 дугаар тушаалаар 7 нэр төрлийн 3,2 сая төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг яамны албан хаагчдад олгосон. Мөн Эника органик импекс ХХК-аас 4 төрлийн 10 сая төгрөгний үнэ бүхий Биологийн идэвхит бүтээгдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулан тараасан. | |
| 105. | ЗГҮАХ 2.1.12.2 | УАБТ-нд хийсэн | Ус сувгийн | 2 аймагт аудит, 4 | III улирал | НЭМГ- | Усны аюулгүй байдлын | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлнэ. | аудитын дүгнэлт, санал | удирдах газар болон 10 аймгийн ус хангагч байгууллагын УАБТ-нд аудит хийсэн. | жижиг суурин газарт УАБТ-г боловсруулах, УАБТ-ний хэрэгжилт 50 хувиас доош байгаа 2 хангагч байгууллагад талбарын сургалт, усны чанар, аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийсэн байна. | | УСХЗХ | төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй орон нутаг болон нийслэлийн байгууллагад хөндлөнгийн аудит хийж зөвлөмж хүргүүлэн ажилласан. Үүнд:<br>• “Дорноговь аймагт 2021 оны 08 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд ус хангагч байгууллагад хэрэгжиж буй усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийх зохион байгуулж ажилласан ба тайлан, зөвлөмжийг 1а/4880 албан тоотоор аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.<br>• Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газарт 2021 оны 07 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийж тайлан зөвлөмжийг 2/4827 албан тоотоор Ус сувгийн удирдах газарт хүргүүлсэн.<br>• Нийслэлийн хүн амын ариун цэврийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх ажлын хүрээнд 2021 оны 5-р сарын 17-21 өдрүүд болон 2021 оны 11-р сарын 02-15 өдрүүдэд 2 удаа удирдамж батлуулан хөндлөнгийн аудитын баг ажилласан бөгөөд тайлан, зөвлөмжийг албан тоотоор НЗДТГ-т хүргүүлсэн.<br>Багануур дүүргийн ЭМТ 2021 оны 3-р сарын 15-19, Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төв, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны эрүүл мэндийн төв”-д 2021 оны 6-р сарын 3-12, “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг болон Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв”-д 2021 оны 08 дугаар сарын 2-6-ны өдрүүдэд тус тус сургалт зохион байгуулж, төлөвлөгөөний төсөл боловсруулсан. Нэгдсэн тайланг ДЭМБ-д 2021.08.30-нд хүргүүлсэн.<br>Багануур дүүргийн ЭМТ-д 2021 оны 3-р сарын 15-19, Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ЭМТ-д 2021 оны 6-р сарын 3-12, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг болон Эрдэнэ сумын ЭМТ-д 2021 оны 08 дугаар сарын 2-6-ны өдрүүдэд тус тус сургалт зохион байгуулж, төлөвлөгөөний төсөл боловсруулсан. | |
| 106. | ТЭМТББХТ 1.10.1.6<br><br>Сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | Журмыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна байна. | II улирал | НЭМГ-ХӨХ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалаар “Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах журам”, “Сүрьеэгийн тохиолдлыг мэдээлэх, тандах, бүртгэх, тайлагнах журам”, “Сүрьеэгийн халдвараас сэргийлэх, хянах журам”, “Сүрьеэгийн дэгдэлтийг тандах, хянах, хариу арга хэмжээг зохион байгуулах журам”, “Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний эмчилгээний | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | асуудлыг шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөний журам", "Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний хяналт-шинжилгээ, үнэлгээний журам", "Сүрьеэгийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар"-ыг тус тус баталсан. | |
| 107. | ТЭМТББХТ: 1.10.1.7, 1.10.1.8<br><br>БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээг зохион байгуулах журмыг боловсруулж, батлуулна. | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | Журмыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна байна. | III улирал | НЭМГ-ХӨХ | ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээний журам, зааврын төслийг боловсруулж, хамтрагч байгууллагуудаас санал авч байна. | 70.0 |
| 108. | ТЭМТББХТ 1.10.1.8<br><br>Сүрьеэ илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | Илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо | - | Сүрьеэ илрүүлэг үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | I-IV улирал | НЭМГ-ХӨХ | Сүрьеэгийн илрүүлэг үзлэгийг 2021-05-20-оос зохион байгуулсан.<br>Нийт 68,853 иргэнийг сүрьеэгийн илрүүлэг үзлэгт хамруулахаар төлөвлөж, 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 66,926 (хамралт 89.6 хувь) иргэнийг хамруулсан. Үүнээс 65,338 иргэнд рентген шинжилгээ, 1,650 иргэнд цэрний шинжилгээ хийж, 177 сүрьеэгийн шинэ тохиолдлыг илрүүлсэн. Орон гэргүй эмзэг бүлгийн 65 иргэн сүрьеэ өвчтэй оношлогдсон байна. | 100.0 |
| 109. | ЗГҮАХ 2.1.12.5<br>Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын агаарын чанарын | Хэрэгжилтийн тайлан | - | 2 Өрхийн эрүүл мэндийн төвд Агаар сэлгэлтийн механик систем, 10 ӨЭМТ-д | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Швейцарын Хөгжлийн Агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтарсан санхүүжилттэй<br>Эх, хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэд бүтцийг сайжруулна. | | | агаарын чанарыг хянах бага оврын төхөөрөмжийг суурилуулсан; 100 өрхөд Монгол гэрийн дулаалга, халаалтын багцыг нэвтрүүлсэн; БХ аймгийн агаарын чанарын хяналтын харуулын мэдээллийг үндэсний мэдээллийн системтэй холбосон байна. | | | нөлөөллийг бууруулах нь төслийн хүрээнд нийт 283 өрх (Баянхогор аймагт 101 өрх, Говь-Алтай аймагт 100 өрх, Өмнөговь аймагт 82 өрх, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт тус тус 90 өрх) монгол гэрийн дулаалга, халаалтын багц буюу ЧИП багцыг шинээр хүлээн авсан байна.<br>Төслөөс 10 ӨЭМТ-д 20 ширхэг агаарын чанарыг хянах бага оврын төхөөрөмжийг суурилуулах 22 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэн Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Баянхонгор аймгийн эрүүл мэндийн газарт хуваарилаад байна.<br>Баянхонгор аймгийн агаарын чанарын хяналтын харуулын мэдээллийг үндэсний мэдээллийн системтэй холбох ажлыг Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран хэрэгжүүлж байна. | |
| 110. | ЗГҮАХ 2.1.10.1 Хүний эрхийн асуудлаар Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулна. | Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл | - | Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | IV улирал | БТГ-СТХ | Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн .13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үйл ажиллагааг эхлүүлээд байна. Хуульд орсон нэмэлт өөрчлөлт бүрийн хуулийн төслийн үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх, хуулийн зүйл заалтыг бусад хэрэгжиж байгаа | 0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон шинээр боловсрогдож байгаа хуулийн зүйл заалттай уялдуулах зэрэг үйл ажиллагаааг эхлүүлсэн. | |
| | | | | | | | | |
| 112. | Эх, хүүхдийн тухай хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулна. | Засгийн газрын тогтоол | - | Хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | II улирал | ЭТҮГ-АЛШТХ | “Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хууль”-ийн төсөлд ЭХЭМҮТ 2 зөвлөхтэй гэрээ байгуулан ажиллаж, хуулийн танилцуулга, хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлал, хуулийн судалгаа, хуулийн эдийн засгийн тооцоолол зэргийг бэлэн болгосон. ЭМЯ-ны УЗХ-аар хэлэлцүүлж яамдын санал авахаар бэлтгэж байна. | 50.0 |
| 113. | Донорын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах | УИХ-р хэлэлцүүлсэн хууль | - | Хуулийн төслийг хэлэлцүүлсэн байна. | II- IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | ТБНД-ын тушаалаар 2021 оны А/69 дүгээр тушаалаар хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсэг “Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай харьцуулан 2021 оны 04 дүгээр сарын 29-ны Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хурлаар хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгийн үр дүнд ирүүлсэн саналыг тусган боловсруулж, 2021 оны 05 дугаар сарын 21-нд Төрийн нарийн бичгийн даргын ахалсан ажлын хэсгийн уулзалтаар төслийг эцэслэн хэлэлцэж 2021 оны 05 дугаар сарын 24-ны 1а/2710 дугаар албан бичгээр засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 70.0 |
| 114. | ЗГҮАХ 2.1.13.1, | Шинэчлэгдэн | Одоогийн | Өрхийн эрүүл | I-IV улирал | ЭТҮГ- | “Өрхийн эрүүл мэндийн төвийн | 90.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ТЭМТББ 2.4.2.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ. | батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо | хүчин төгөлдөр баримт бичгүүд 2017, 2019 онд батлагдсан. | мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийсэн байна. | | АЛШТХ | үлгэрчилсэн дүрэм"-ийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/212 тоот тушаалаар шинэчлэн баталсан.<br>Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад мөрдөгдөж байгаа эрх зүйн бусад баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ЭМС-ын 2021 оны А/412 тоот тушаалаар байгуулж, ӨЭМТ-тэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээ сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн төслийг бэлэн болгож, газар хэлтсээс санал авч байна. | |
| 115. | Нярайн сурфактант эмчилгээ үйлчилгээтэй холбоотой явцын үнэлгээ хийх, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Нярайн сурфактант эмчилгээг нэвтрүүлсэн байгууллагын тоо | 25 Эрүүл мэндийн байгууллага нярайн сурфактант эмчилгээг хийж, үр дүн 76,5% байсан. | Нярайн сурфактант эмчилгээний үр дүнг 90%-д хүргэнэ. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Суурь түвшиндээ байгаа | 0 |
| 116. | "Эх яагаад эндэв" судалгааны дүнг танилцуулна. | Судалгааны тайлан | "Эх яагаад эндэв" судалгааг жил бүр хийж, шийдвэр гаргагч нарт танилцуулдаг. | Судалгааны дүн гарч, шийдвэр гаргагч нарт танилцуулсан байна. | I-III улирал | ЭТҮГ-АЛШТХ | "Эх яагаад эндэв? (2016-2019) итгэмжит лавлагаа" 5 дахь удаагийн судалгааг ЭМЯ, ЭХЭМҮТ-ийн хамтарсан баг НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр хийж, нийт 97 тохиолдлыг судлан эхийн эндэгдлийг бууруулахад чиглэсэн 9 бүлэг дүгнэлт, зөвлөмжийг гарган 2 удаагийн цахим хурлаар орон нутаг, нийслэлийн ЭМБ-ын нийт 200 гаруй эмч мэргэжилтнүүдэд танилцуулсан. Бодлого | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулагч, иргэдэд зориулсан 12 ширхэг баримтын хуудас боловсруулсан, судалгааны тайланг англи хэлээр хэвлүүлсэн. | |
| 117. | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг оношилж, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Оношилгоонд хамруулсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь | Сүүлийн 4 жилд эндсэн эхчүүдийн 83 хувь нь архаг суурь өвчтэй байна. | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 50 хувийг архаг, суурь өвчнийг илрүүлэх оношилгоонд хамруулсан байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 90.5 хувь нь жирэмсний эрт үеийн хяналтад орж шаардлагатай шинжилгээнүүдэд хамрагдаж, эрүүлжүүлэх ажил хийгдэж байна.<br>ХСҮТ-д байгуулагдсан хөхний төвийн үйлчлүүлэгчдийн тоо өдөрт 15-20 хүн байсан бол 40-50 болж өссөн. | 30.0 |
| 118. | Хүүхдийн хавдрын эсрэг глобал санаачлагын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхэлнэ. | Эрүүл мэндийн сайдын тушаал Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хавдаргүй үрс үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулсан. Дэлхийн санаачлагад нэгдсэн. | Хүүхдийн хавдрын эсрэг глобал санаачлагын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Хүүхдийн хорт хавдартай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/201 дүгээр тушаалаар хүүхдийн хорт хавдрын тусламж, үйлчилгээ, хяналтыг сайжруулах 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.<br>“Хүүхдийн хавдрын тусламж, үйлчилгээг эрчимжүүлэх” Зохицуулах зөвлөлийн 3 удаагийн хуралдааныг зохион байгуулж, хурлын шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Хүүхдийн хорт хавдартай тэмцэх олон улсын өдрийг тохиолдуулан хорт хавдрыг амжилттай эмчлүүлсэн хүүхдийн талаар “ЭРТ ОНОШИЛГОО, ТУУШТАЙ ЭМЧИЛГЭЭ ХАВДРЫГ ЯЛАН ДИЙЛЭХ ҮНДЭС” богино хэмжээний видео хийж, “Хорт | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хавдартай бүх хүүхдийг эмчилье" техникийн багцыг танилцуулах нээлтийн арга хэмжээнд танилцуулав. | |
| 119. | ЗГҮАХ 2.1.13.2 Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ. | Шинэчлэгдэн батлагдсан Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний багц, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Одоогийн хүчин төгөлдөр баримт бичгүүд 2019 онд батлагдсан | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлж эхэлнэ. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Эрүүл мэндийн анхан шатны байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээний журам жагсаалтад ажлын хэсгийн гишүүдээс санал аваад байна. | 50.0 |
| 120. | ЗГҮАХ 2.1.13.3 Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно. | ТББ-аас Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийсэн тоо | - | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хөндлөнгийн төрийн бус байгууллагаар үнэлгээ хийгдсэн байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Эрүүл мэндийн сайдын 2014 оны 13 дугаар тушаалаар батлагдсан "Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах аргачлал"-ыг шинэчлэн боловсруулсан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээ хийх журмын төсөлд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.6 дугаар заалт, ЗГХЭГ-ын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар батлагдсан "Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж"-ийн холбогдох заалт, ДЭМБ | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон бусад улсын ижил төстэй аргачлалыг өөрийн орны нөхцөлд уялдуулан тусгасан болно. Энэхүү журмын төсөлд 2021 оны 07 дугаар сард багтаан байгууллагуудаас санал авч, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах төлөвлөгөөтэй байна. Батлагдсан удирдамжийн дагуу ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоотой хамтран Улаанбаатар, Баян-Өлгий, Увс, Говьсүмбэр, Сэлэнгэ, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн сонгож авсан 27 өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 12 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл 11 бүлэг, 65 асуумж бүхий үнэлгээний хуудсаар дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж ажиллав. | |
| 121. | ЗГҮАХ 2.1.13.4 Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг шинэчлэнэ. | Батлагдсан журам | - | Журам шинэчлэн батлагдсан байна. | I-IV улирал | СЭЗГ-СДХ БТГ-СУХ | Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 257/А/562 дугаар тушаалаар батлагдсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу нэг иргэнээр тооцсон аргачлалыг Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор хүчингүй болгож ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолоор шинэчлэн | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлуулсан. | |
| 122. | ЗГҮАХ 2.1.14.1 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно. | Шинээр орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болсон сумын ЭМТ-ийн тоо | - | 60 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | БНСУ-ын КОЙКА байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймагт хэрэгжүүлж буй “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн хүрээнд 4 сумын ЭМТ-ийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах ажил хийгдсэн. Үүнд: Баянхонгор аймгийн Заг сумын Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний өргөтгөл, Говь-Алтай аймгийн Бугат сумын халдвартын эмнэлэг, Хөхморьт сумын ЭМТ-ийн ариун цэврийн байгууламжийн сайжруулалт, Завхан аймагт Цагаанчулуут сумын эмнэлэгт зөөврийн контейнер ашигласан ариун цэврийн байгууламж байгуулах ажил хийгдсэн. | 30.0 |
| 123. | ЗГҮАХ 2.1.14.2 Сумдын эмнэлгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах зураг төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. | Батлагдсан ажлын даалгавар, зураг төсөл | - | Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд төсөвт өртгийг 24,3 тэрбум, санхүүжих дүнг 3,0 тэрбум төгрөгөөр тусгасан бөгөөд нэг маягийн давтан хэрэглэгдэх зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар боловсруулж барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна. | 100.0 |
| 124. | Алсын хараа- 2050 2.2.23 | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо, | - | Хэлэлцүүлгийг зохион байгуулж, | I-II улирал | ЭТҮГ-УАУХ | Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний дараах | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, экспортод гаргах гарц, бренд болгон хөгжүүлэх талаар үе шаттай хэлэлцүүлэг зохион байгуулна. | хэлэлцүүлгээс гарах зөвлөмж | | нэгдсэнзөвлөмж гарсан байна. | | | чиглэл бүрээр хэлэлцүүлэг 2021 онд зохион байгуулсан байна:<br>• Уламжлалт эм үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал<br>• Уламжлалт эмийн үйлдвэрийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам<br>• КОВИД-19 халдварын үед хэрэглэгдэж байгаа уламжлалт эмийн эмчилгээний үр дүн<br>• Уламжлалт анагаах ухааны нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ<br>• Сум, сум дунд, тосгоны ЭМТ-д ажиллаж байгаа уламжлалт анагаах ухааны эмнэлгийн мэргэжилтнүүдэд тулгамдаж байгаа асуудал<br>• Монголын уламжлалт анагаах ухааны эмнэлгийн тусламж, үйлчилгээний нөхцөл байдал, цаашдын хөгжлийн чиг хандлага<br>Дээрх хэлэлцүүлгээс гарсан санал, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр нэгдсэн зөвлөмж гаргаж, Эрүүл мэндийн яамны Уламжлалт анагаах ухааны Мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлсэн. | |
| 125. | ТЭМТББТ2.8.1.2 Ханиур засал эмчилгээний заавар | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | III улирал | ЭТҮГ-УАУХ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/152 тушаалаар Ханиур засал эмчилгээний заавар батлагдсан. | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж батлуулна. | | | | | | | |
| 126. | ТЭМТББТ2.8.1.2 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгуулагуудад үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | - | Үнэлгээ хийж, үнэлгээний тайлан боловсруулан УЗ-өөр хэлэлцүүлсэн байна. | II- IV улирал | ЭТҮГ-УАУХ | Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлын удирдамжийг 2021 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Бодлогын баримт бичиг, эрх зүйн орчин, хүний нөөц, тусламж, үйлчилгээний орчин нөхцлийг үнэлж, үнэлгээний дүнг үе шаттай ЭЭХХЗГ, Мэргэжлийн салбар зөвлөл, НЭМҮТ, уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулсан. Мөн ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхд бэлэн болгоод байна. | 90.0 |
| 2.3. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | | |
| 127. | ЗГҮАХ 2.3.1.1 Яслийн үйлчилгээ нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлнэ. | Санал өгч батлагдсан шийдвэр | - | Яслийн 60 бүлэгт 900 хүүхэд хамруулсан байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | БШУЯ, УОК, ЭМЯ, ХӨСҮТ, ОБЕГ зэрэг мэргэжлийн байгууллагууд хамтран үнэлгээ хийж, цартахлын нөхцөл байдал, томуугийн дэгдэлт, хүүхдийн эмнэлгийн орны хүрэлцээ зэргээс шалтгаалан 2022 он гартал 2-3 настныг яслид хамруулахыг хойшлуулаад байна. | 30.0 |
| 128. | ЗГҮАХ 2.3.2.6 Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дундын хамтын | Батлагдсан бодлого | - | Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг баталсан байна. | I-IV улирал | НЭМГ | БШУЯ-тай хамтран Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр (2021-2030 он)-ийн төслийг боловсруулсан. | 30.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг бэхжүүлнэ. | | | | | | | |
| 129. | ЗГҮАХ 2.3.4.6 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгоно. | Хамтран ажилласан арга хэмжээ | - | Сургалтын хөтөлбөрийг сайжруулж, багш бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | I-IV улирал | НЭМГ | Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг БШУЯ дангаараа боловсруулсан. Хүүхдэд тэгш хүртээмжтэй үйлчлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох комиссын чиг үүрэг, зохицуулалтыг боловсруулахад БШУЯ, ХНХЯ-тай хамтран ажиллаж байна. | 0 |
| 130. | ЗГҮАХ 2.3.8.5 Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлнэ. | Сургагдсан багшийн тоо | - | 165 багшийг мэргэшүүлсэн байна. | I-IV улирал | НЭМГ | БШУЯ-тай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлэх зорилгоор судалгаа хийж, хөтөлбөр боловсруулан батлуулахаар хянагдаж байна. | 30.0 |
| 131. | ЗГҮАХ 2.3.10.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлэнэ. | Стандартын шаардлагад нийцсэн хоолны газартай ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны эзлэх хувь | - | Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын хоолны газрын 20 хувийг стандартын шаардлагад нийцүүлж, өдрийн хоолны үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/75 дугаар тушаалаар баталсан бөгөөд ажлын хэсэгт ажиллаж байна. | 30.0 |
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | |
| 4.2. Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. | | | | | | | | |
| 132. | ЗГҮАХ 4.2.5.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний | Зохион байгуулсан сургалт, сурталчилгааны | Төрийн албаны тухай хууль, Төрийн | Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох | I-IV улирал | ТЗУГ | Яамны албан хаагчдаас нууц санал хураалт авч, дийлэнхи санал авсан 5 албан хаагчийн | 70.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | тоо | албан хаагчийн ёс зүйн дүрмээр зохицуулагдаж байгаа. | байгууллагад хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ. | | | бүрэлдэхүүнтэй ёс зүйн зөвлөлийг Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/86 дугаар тушаалаар байгуулсан. ЭМЯ-ны Ёс зөвлөл нийт 4 удаа хуралдаж зөвлөлийн даргыг сонгож, албан бичиг, тогтоолын загварыг гарган хэвлүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, төрийн албан хаагчаас ирүүлсэн 4 өргөдлийг хэлэлцсэн.<br>ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуультай хамтран “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, төлөвшил, хариуцлага” эрдэм шинжилгээ, онол практикийн улсын анхдугаар цахим хурлыг 2021 оны 02 сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Хуралд 1800 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагч оролцож хурлаас эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хандсан 18 заалт бүхий зөвлөмж гаргаж бүх эрүүл мэндийн байгууллагуудад хүргэгдсэн. 2021 оны эхний 6 сарын байдлаар ЭМБ-ын 8 ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг шинээр томилж, 3 ёс зүйн салбар хороодыг өөрчлөн томилсон тогтоолыг гаргаж хүргүүлсэн. ЭМХТ-тэй хамтран Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн түгээмэл баримтлах зарчим сэдэвт 2 удаагын багц цагийн цахим | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хичээлийг 8800 орчим эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулсан. | |
| 5. Сайд, дэд сайд, удирдлага болон яамны аппаратын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх | | | | | | | | |
| 133. | Эрүүл мэндийн сайдтай Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2021 онд хамтран ажиллах гэрээг байгуулна. | Гарын үсэг зурж, баталгаажсан гэрээ | Гэрээг жил бүр байгуулдаг. | Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2021 онд хамтран ажиллах гэрээг байгуулж, батлуулсан байна | I улирал | БТГ-СУХ | Эрүүл мэндийн сайд, Аймаг, нийслэлийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээг 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр байгуулж, КОВИД-19-ын үед аймаг, орон нутгийн удирдлагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг бие даасан зүйл болгон тусгасан. Мөн гэрээнд салбарын санхүүжилтийн чиглэлээр хэрэгжиж байгаа гүйцэтгэлийн санхүүжилтийн өөрчлөлтийг тусгасан. | 100.0 |
| 134. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Засгийн газарт хүргүүлнэ. | Засгийн газарт хүргүүлсэн тайлан | Тайланг улирал тутам хүргүүлдэг. | Засгийн газарт тайланг улирал тутам хүргүүлсэн байна. | I-IV улирал | ТЗУГ-ХХ | ЗГХЭГ-ын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ЭМЯ хариуцан шийдвэрлэх 1160 гомдлыг хүлээн авч, гомдол гаргасан иргэдтэй нэг бүрчлэн утсаар холбогдон гомдлыг сонсож, холбогдох газарт нь утсаар болон биечлэн уламжилж ажилласан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 99%-тай байна. 9 гомдол нь шийдвэрлэх хугацаанд байна.<br>Өргөдөл гомдлын 1, 2, 3 дугаар улирлын тайланг гаргаж, 2/3570, 2/5254, 2/1621 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Жилийн эцсийн тайланг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны дотор ЗГХЭГ-т хүргүүлнэ. | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 135. | Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Батлагдсан төлөвлөгөө | Жил бүр ЭМЯ-ны УЗ-ийн хурлаар хэлэлцэн баталдаг. | Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. | I улирал | ТЗУГ | Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, ЭМЯ-аас 2021 онд УИХ-аар, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын чиглэлтэй уялдуулан боловсруулж, батлуулсан.<br>ЭМЯ-ны бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбоотой яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дахин хянаж, холбогдох газар, хэлтсийн дарга нартай зөвшилцөн чиг үүргийн дагуу хариуцах газар, хэлтэст өөрчлөлт оруулж ТНБД, Эрүүл мэндийн сайдаар 2021 оны 11 сарын 01-нд дахин батлуулж, газрын дарга нарт хүргүүлсэн. | 100.0 |
| 136. | ЭМЯ-ны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулна. | ТАЗ-өөр хянагдаж, баталгаажсан АБТ-ын тоо | ЭМЯ-ны бүтэц шинэчлэгдэн батлагдсан. | ЭМЯ-ны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан байна. | I-IIулирал | ТЗУГ | Төрийн албаны тухай хууль, ТАЗ-ийн 02,03 дугаар тогтоолын дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг ТНБД-ын 2021 оны А/46 дугаар тушаалаар байгуулсан. Яамны бүтэц, зохион байгуулалт 9 сард өөрчлөгдсөнтэй холбогдуулан ажлын хэсгийн бүрхэдэхүүнд өөрчлөлт оруулсан. Яамны төрийн албан | 90.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаагчдын АТТ-ын төслийг боловсруулж, харьцуулсан дүн шинжилгээг хийж ТАЗ-д хүргүүлэн хянуулж байна. | |
| 137. | Дэлхийн эрүүл мэндийн 74 дүгээр чуулганд оролцоно. | Чуулганд оролцсон тайлан, мэдээлэл | Жил бүрийн чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлдэг. | Чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлсэн байна. | II улирал | ТЗУГ- ГХХ | Дэлхийн эрүүл мэндийн 74 дүгээр чуулганы нэгдсэн хуралдаанд Эрүүл мэндийн сайд Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлж үг хэлж оролцсон.<br>Мөн Монгол Улсын Эрүүл мэндийн сайд 74 дүгээр Ассамблейн Дэд Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан. | 100.0 |
| 138. | Ази, Номхон далайн бүсийн Парламентчдын Дэлхийн эрүүл мэндийн VI форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулна. | Форум зохион байгуулсан тайлан, мэдээлэл | Монголд анх удаа зохион байгуулагдана. | Форм зохион байгуулагдаж эрүүл мэндийн асуудлаарх парламентчдын улс төрийн дэмжлэг нэмэгдсэн байна. | II-III улирал | ТЗУГ- ГХХ | 2021 оны 8 дугаар сард форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулах талаар ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн хороо болон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар албан бичгээр харилцан зөвшилцөж тохиролцсон байсан боловч цар тахлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. Форумыг зохион байгуулах шинэ товыг ДЭМБ-аас гаргаагүй байна. Харин 2021 оны 4 болон 12 дугаар саруудад энэ Форумын механизмын хүрээнд зохион байгуулагдсан олон улсын Парламентачдын 2 удаагийн бага хуралд Монгол Улсын Их Хурлын дарга болон УИХ-ын гишүүд оролцсон ба тэдгээрийн хуралд оролцохтой холбоотой бэлтгэл ажлыг хангаж ажилласан. | 90.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 139. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн хорооны 72 дугаар чуулганд оролцоно. | Чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлсэн байна. | Чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлэх | Олон талт хамтын ажиллагаа өргөжин хөгжсөн байна. | IV улирал | ТЗУГ- ГХХ | ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн хорооны 72 дугаар чуулганы хуралдаан 2021 оны 10 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан ба чуулганы хуралдаанд Ажлын удирдамжид заасны дагуу оролцож тогтоол шийдвэр гаргасан бүх асуудлаар Монгол Улсын байр суурийг илэрхийлж үг хэлсэн.<br>Чуулганд оролцсон дүнгийн тухай илтгэх хуудсыг ажлын 3 хоногт багтаан ГХЯ-нд 11 дүгээр сарын 3-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн. | 100.0 |
| 140. | Гадаад хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орон, олон улсын байгууллагын техникийн туслалцааны шинэ төслийн санал боловсруулж, шийдвэрлүүлнэ. | Шинээр хэрэгжүүлсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ | - | Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад эх үүсвэрээс буцалтгүй тусламжийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн байна. | I-IV улирал | ТЗУГ- ГХХ | Япон Улсын Засгийн газарт КОВИД-19 цар тахлын эсрэг вакцинжуулалтыг эхлүүлэхэд Монгол Улсад дэмжлэг үзүүлэх тусламжийн хүрээнд 2 үе шаттай хэрэгжих нийт 21.6 сая ам. долларын төслийг батлуулсан. Төсөл НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжиж хэрэгжих зохицуулалттай. Нийт санхүүжилтээс 15.8 сая ам.долларыг вакцины худалдан авалтад, 861,000 ам.долларыг хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн шинэчлэлтэд, 1.2 сая ам.долларыг эх, нярайн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалтад, үлдсэнийг эрсдлийн үеийн харилцаа холбоо, олон нийтийн оролцооны үйл ажиллагаанд зарцуулна. Үүнээс эхний ээлжинд | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | АНУ-ын Пфайзер Инк компанитай байгуулсан КОВИД-19 халдварын эсрэг вакцин нийлүүлэлтийн гэрээг санхүүжүүлж эхлээд байна.<br>2021 оны 04 дүгээр сард “КОВИД-19 цар тахлын үеийн яаралтай хариу арга хэмжээ” төслийн саналыг боловсруулж, төслийн хүрээнд:<br>- SARS-CoV-2 вирусын генийн өөрчлөлтийг тодорхойлох сексвисинг хийх лабораторийн тоног төхөөрөмж,<br>- Вакцин тээвэрлэх зориулалтын хөргүүр бүхий ачааны машин,<br>- КОВИД-19 халдвар авсан өвчтний биеийн байдал, хүндрэлийн зэргийн өөрчлөлтийг тодорхойлох багаж,<br>- SARS-CoV-2 вирусын антиген илрүүлэх түргэвчилсэн тест кит,<br>зэргийг техникийн туслалцааны хүрээнд авахаар тусгасан. Одоогоор түргэвчилсэн оношлуурын эхний хэсгийг хүлээн авсан.<br>АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагт хандаж “КОВИД-19 цар тахалтай тэмцэх Монгол Улсын эрчимт эмчилгээний чадавхийг сайжруулах” төслийн саналыг боловсруулж, батлуулсан ба төслийн хүрээнд Монгол Улсад 3 ширхэг Явуулын эрчимт эмчилгээний клиникийг буцалтгүй тусламжаар олгох асуудал шийдвэрлэгдсэн.<br>АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагт хандаж тус улсаас | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | буцалтгүй тусламжаар олгосон 50 ширхэг амьсгалын аппаратыг угсарч суурилуулах, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдэд ашиглалт, засвар үйлчилгээний сургалт, эрчимт эмчилгээний багийн мэргэжилтнүүдэд “Амь тэнссэн үеийн амиуулах тусламж, үйлчилгээ”-ний сургалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн хэсэг бүхий 350,000 ам.долларын санхүүжилттэй техникийн хамтын ажиллагааны төслийг батлуулсан. Сургалтууд зохион байгуулагдсан. Нэмэлтээр 50 ширхэг хиймэл уушиг худалдан авч сургалтад ашиглах хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн. Хиймэл уушигны худалдан авалтыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг зохион байгуулсан бөгөөд 10 дугаар сард хүлээн авсан.<br>2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Олон улсын вакцины холбоо-ВДГА-д хандаж хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн албан хүсэлтийг хүргүүлж, 2021 оны 04 дүгээр сард 70,000 ам.долларын үнэ өртөг бүхий вакцины хөргөгч, хөлдөөгчийг 2021 онд багтааж буцалтгүй тусламжаар олгох болсон хариуг Эрүүл мэндийн сайдад ирүүлсэн. | |
| 141. | Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орон, олон улсын | Шинээр хэрэгжүүлсэн төслийн тоо, санхүүжилтийн | - | Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд | I-IV улирал | ТЗУГ- ГХХ | Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-д хандаж тус яамны харьяа Эх, нярай, | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын техникийн туслалцааны шинэ төслийн санал боловсруулж, шийдвэрлүүлнэ. | хэмжээ | | гадаад эх үүсвэрээс буцалтгүй тусламжийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн байна. | | | эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-т түргэн тусламжийн тоноглогдсон автомашин, эмнэлгийн нэн шаардлагатай зарим тоног төхөөрөмжийг хангуулахаар “КОВИД-19 халдвараас сэргийлэх, хянах, эмчилгээ, эмнэлгийн тусламж үзүүлэх чадавхийг сайжруулах нь” Техникийн хамтын ажиллагааны төслийн саналыг шинээр боловсруулж, 2021 оны 2-р сарын 19-ний өдөр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 3-р сарын 17-ны өдөр ЖАЙКА-тай цахим уулзалт хийхэд дээрх техникийн хамтын ажиллагааны төсөл батлагдсан болохыг урьдчилан мэдэгдсэн. 5 дугаар сарын 28-ны өдөр Эрүүл мэндийн сайд, ЖАЙКА Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгч нар дээрх төслийг хэрэгжүүлэх Санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан. Худалдан авалтыг ЖАЙКА Олон улсын хамтын ажиллагааны агентлаг зохион байгуулж байгаа. Уг Техникийн туслалцааны төслийн хүрээнд нийлүүлэгдэх ачаа бараа Япон Улсаас далайгаар тээвэрлэгдэн БНХАУ-ын хил дээр /Тянжинь боомт/ гацсан байгаа ба 2022 оны 1 дүгээр сардаа багтаан хилээр татан авах төмөр замын тээвэрлэлтэд оруулахаар ажиллаж байна. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 142. | Буцалтгүй тусламжийн санхүүжилтээр шинэ төслийн санал боловсруулж, олон улсын банк санхүүгийн байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ. | Шинээр хэрэгжүүлсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ | | Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад эх үүсвэрээс буцалтгүй тусламжийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн байна. | I-IV улирал | ТЗУГ- ГХХ | Буцалтгүй тусламжийн санхүүжилтээр шинэ төслийн санал боловсруулж, шийдвэрлэх чиглэлээр дараах ажлыг зохион байгууллаа. Үүнд:<br>- АХБ-нд төслийн санал 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр хүргүүлсэн нь батлагдаж, 5 сая ам.долларын санхүүжилттэй MON-9218: “Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд молекул биологийн ПГУ шинжилгээ хийх иж бүрэн 10-12 лаборатори байгуулж, вакцинжуулалтад шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл худалдан авах, насанд хүрэгчдийн сэргийлэх тарилгын олон улсын гэрчилгээг хэвлүүлэх зардлыг бүрэн шийдвэрлэсэн.<br>- Япон Улсын Засгийн газарт КОВИД-19 цар тахлын эсрэг вакцинжуулалтыг эхлүүлэхэд Монгол Улсад дэмжлэг үзүүлэх хүсэлт тавьсны дагуу 2 үе шаттай хэрэгжих нийт 21,6 сая ам. долларын буцалтгүй тусламжийг батлуулсан. Төсөл НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжиж хэрэгжих зохицуулалттай. Нийт санхүүжилтээс 15.8 сая ам. долларыг вакцины худалдан авалтад, 861,000 ам. долларыг хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн шинэчлэлтэд, 1,2 сая ам. долларыг эх нярайн | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалтад, үлдсэнийг эрсдлийн үеийн харилцаа холбоо, олон нийтийн оролцооны үйл ажиллагаанд зарцуулна. Үүнээс эхний ээлжинд АНУ-ын Пфайзер Инк компанитай байгуулсан КОВИД-19 халдварын эсрэг вакцин нийлүүлэлтийн гэрээний санхүүжилтэд 18,5 сая ам. долларыг зарцуулсан.<br>- 2021 оны 4 дүгээр сард “КОВИД-19 цар тахлын үеийн яаралтай хариу арга хэмжээ” төслийн саналыг боловсруулж, ЖАЙКА-д албан ёсоор тавьж шийдвэрлүүлсэн. Санхүүжилт: 883 сая иен. Үүнд: (1) SARS-CoV-2 вирусын генийн дараалыг тодорхойлох лабораторийн 2 иж бүрдэл тоног төхөөрөмж, 1 жил хэрэглэх урвалж бодисын хамт, (2) вакцин тээвэрлэх зориулалтын хөргүүр бүхий ачааны машин 1, (3) вакцин тээвэрлэх зориулалтын хөргүүр бүхий дунд оврын суудлын автомашин 1, (4) спирометр 530 ширхэг, (5) SARS-CoV-2 вирусын антиген илрүүлэх түргэвчилсэн тестний 50,000 кит /500,000 ш тест/, (6) дархлаажуулалтын бүртгэл мэдээлэлд ашиглах зориулалтаар 548 ширхэг зөөврийн компьютер. Антиген тест 2021 оны 12 дугаар сараас нийлүүлэгдэж эхэлсэн ба бусад | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тоног төхөөрөмжүүд 2022 оны 2 дугаар сард нийлүүлэгдэх төлөвлөгөөтэй.<br>- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагт хандаж боловсруулж “КОВИД-19 цар тахалтай тэмцэх Монгол Улсын эрчимт эмчилгээний чадавхийг сайжруулах” төсөл батлагдсан ба төслийн хүрээнд Монгол Улсад 3 ширхэг Явуулын эрчимт эмчилгээний клиникийг 700,000 ам. долларын буцалтгүй тусламжаар олгох асуудал бүрэн шийдвэрлэгдсэн.<br>- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагт хандаж тус улсаас буцалтгүй тусламжаар олгосон 50 ширхэг амьсгалын аппаратыг угсарч суурилуулах, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдэд ашиглалт, засвар үйлчилгээний сургалт, эрчимт эмчилгээний багийн мэргэжилтнүүдэд “Амь тэнссэн үеийн амиуулах тусламж үйлчилгээ”-ний сургалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн хэсэг бүхий 350,000 ам.долларын санхүүжилттэй техникийн хамтын ажиллагааны төслийг батлуулсан. Сургалтууд зохион байгуулагдсан. Нэмэлтээр 50 ширхэг хиймэл уушги худалдан авч сургалтад ашиглах хүсэлт тавьж бүрэн шийдвэрлүүлсэн.<br>- Олон улсын вакцины холбоо-ВДГА-д хандаж хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн албан | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүсэлтийг хүргүүлсний дагуу Монгол Улсад 70,000 ам.долларын үнэ өртөг бүхий вакцины хөргөрч, хөлдөөгчийг буцалтгүй тусламжаар олгосон | |
| 143. | Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын эрүүл мэнд, нийгмийн халамжийн яам хоорондын Зөвлөлдөх ажлын хэсгийн ээлжит хуралдааныг зохион байгуулна. | Хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний батлагдсан төлөвлөгөө | Зөвлөлдөх ажлын хэсэг жил бүр хуралддаг. | Төлөвлөгөөт арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна. | III-IV улирал | ТЗУГ-ГХХ | Хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулах талаар ГХЯ-аар дамжуулж 2021 оны 6 дугаар сард 1, 2021 оны 10 дугаар сард 1 албан бичгийг тус тус илгээсэн. | 30.0 |
| 6. Салбарын хуультогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийн зарцуулалтад хяналт, шалгалт, дотоод аудит хийх. | | | | | | | | |
| 144. | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Сангийн яаманд хүргүүлдэг | Үнэлгээний дүнг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн байна. | Iулирал | ХШҮДАГ | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2020 оны хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж дүнг 1а/365 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100.0 |
| 145. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг | Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | I,II улирал | ХШҮДАГ | - Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | | | | | | Дүнг 1а/456 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2021 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Дүнг 1а/3700 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2021 оны 3 улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. | |
| 146. | Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг | Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Засгийн газрын тогтоолоор батлагдсан 12 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/2866 тоот тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100.0 |
| 147. | “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”- | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Засгийн | Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх | I улирал | ХШҮДАГ | “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд 2020 оны жилийн | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ын хэрэгжилтэд явцын үнэлгээ хийнэ | | газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг | газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | | | эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/1890 тоот тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| 148. | Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Үндэсний хөгжлийн газарт хүргүүлдэг | Үнэлгээний дүнг Үндэсний хөгжлийн газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн салбарын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 2/455 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. | 100.0 |
| 149. | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ | Үнэлгээний дүн | - | Үнэлгээний дүнг Үндэсний хөгжлийн газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | III улирал | ХШҮДАГ | “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн 2021 оноос хэрэгжиж эхэлсэн тул бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхгүйгээр 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг Үндэсний хөгжлийн газарт 2/4931 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100.0 |
| 150. | Засгийн газрын 2017 оны 225 тогтоол, “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийнэ. | Үнэлгээний дүн | - | Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | II-IV улирал | ХШҮДАГ | “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг боловсруулсан. | 90.0 |
| 151. | Засгийн газрын 2013 | Үнэлгээний дүн | - | Үнэлгээний дүнг | II-IIII улирал | ХШҮДАГ | “Эрүүл насжилт, настны эрүүл | 30.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оны 225 тогтоол, “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийнэ. | | | Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | | | мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамж боловсруулж, Эрүүл мэндийн сайдаар 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Үнэлгээний хүрээнд Геронтологийн үндэсний төв, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох албан тушаалтантай хамтран ажиллаж хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж байна. | |
| 152. | Засгийн газрын 2017 оны 112 тогтоол, “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ хийнэ. | Үнэлгээний дүн | - | Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | III-IV улирал | ХШҮДАГ | | 0 |
| 153. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг | Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | I, II улирал | ХШҮДАГ | - Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний дүнг 2021 оны 1а/233 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг 2021 оны 1а/1917 тоот албан бичгээр | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний дүнг 2021 оны 1а/3707 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний дүнг 2021 оны 1а/4879 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 8.6 дахь заалтын дагуу эрүүл мэндийн салбарын хяналтад байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зарим заалтуудыг Эрүүл мэндийн яамны дотоод хяналтад авч, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтаас хасуулах саналыг ЗГХЭГ-т 2021 оны 1а/6124 тоот албан бичгээр хүргүүлж, үнэлгээний мэдээллийн сан http://new.unelgee.gov.mn/law/-д саналыг оруулж | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баталгаажуулсан. | |
| 154. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигийн дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг эрүүл мэндийн мэдээллээр хангана. | Мэдээллийн тоо | Холбогдох мэдээлэл, тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлдхүргүүлдэг | Мэдээлэл, тайланг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хугацаанд нь хүргүүлсэн байна. | I-IV улирал | ХШҮДАГ | - Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг эрүүл мэндийн холбогдох 5 төрлийн мэдээллээр хангаж ажилласан. 2020 оны сүүлийн хагас жилийн байдлаар Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ; Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хянах, эмчлэх үйл ажиллагаа, үзүүлэлтийн тухай мэдээ, тайлан; Эрүүл мэндийн салбарт шинээр болон шинэчилсэн стандартуудын тухай; Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ; Зүрхний төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ зэрэг 5 хавсралт бүхий танилцуулах мэдээг 2/765 тоот албан бичгээр ҮАБЗ-д хүргүүлсэн.<br>- 2021 оны эхний 06 сарын байдлаар Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ; Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хянах, эмчлэх үйл ажиллагаа, үзүүлэлтийн тухай мэдээ, тайлан; Эрүүл мэндийн салбарт шинээр болон шинэчилсэн стандартуудын тухай; Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ; Зүрх, мэдрэлийн төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ; Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, явцын тухай мэдээ, тайлан зэрэг 6 хавсралт бүхий | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулах мэдээг 2/4173 тоот албан бичгээр ҮАБЗ-д хүргүүлсэн. | |
| 155. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудын болон төсөл, хөтөлбөрийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, шилэн дансны хөтлөлтөд улирал тутам хяналт тавина. | Шилэн дансны цахим санд байршуулсан мэдээлэл | Холбогдох мэдээлэл, тайлангСангийн яаманд улирал тутам хүргүүлдэг | Холбогдох мэдээлэл, тайланг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн байна. | I-IV улирал | ХШҮДАГ | - Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай 2021 оны 2/402 тоот албан бичгийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ, аймаг, нийслэлийн ЭМГ, төсөл, хөтөлбөрийн дарга, захирал нарт хүргүүлсэн.<br>- Тайлангийн хугацаанд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангасан байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хуулийн хугацаанд байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах албан тоотыг харъяа байгууллагад болон дотоод меморандумыг ЭМЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэн хяналт тавьж ажилласан.<br>- Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын мэдээллийг шилэн дансанд байршуулсан байдалд хяналт, үнэлгээ хийж танилцуулга боловсруулсан.<br>- 2021 онд улирил бүр Шилэн дансны тайланг Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн.<br>- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт Эрүүл мэндийн яамны харьяа 19 байгууллагын тухайд 92.5 хувь, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газруудын хувьд 90.7 хувь, салбарын хэмжээнд 92.0 хувийн хэрэгжилттэй байна. | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 156. | УИХ-ын 2019 оны 62 тогтоол, 1.4.г, Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний дүн | - | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, конвенцид заасан зохицуулалттай нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна. | II-III улирал | ХШҮДАГ | Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж боловсруулан Эрүүл мэндийн сайдаар 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр батлуулсан. | 30.0 |
| 157. | Эрүүл мэндийн яамны 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг | Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн яамны 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний дүнг 1а/1425 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Эрүүл мэндийн яамны бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг боловсруулж, ТНБД-аар батлуулсан. Төлөвлөгөөг 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн Дотоод меморандум №49-аар газар, хэлтсийн дарга нарт өгсөн. | 100.0 |
| 158. | Эрүүл мэндийн байгууллагуудын 2020 оны үйл | Үнэлгээнийдүн | Жил бүр үнэлгээ хийж, санал | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, | I улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/44 дүгээр тушаалын дагуу | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | | зөвлөмж гардаг | Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн гүйцэтгэлийн үр дүнгийн тайланг эрүүл мэндийн байгууллагууд руу хүргүүлсэн байна. | | | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 2020 оны гүйцэтгэлийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гаргасан. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ 90.1%, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газруудын 2020 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ 87.8% тус тус байна. Үнэлгээний дүнг Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн сайдад тус тус танилцуулсан. Үнэлгээнээс гарсан зөвлөмжийг 2021 оны 2/3331 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. | |
| 159. | Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам шинэчлэн боловсруулна. | Эрүүл мэндийн сайдын тушаал | Журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулдаг | Журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | I-II улирал | ХШҮДАГ | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлагдаж, тушаалыг Эрүүл мэндийн байгууллагуудад 2021 оны 8/5283 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100.0 |
| 160. | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/422 тушаалын | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Засгийн | Үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх | II улирал | ХШҮДАГ | - Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2020 онд байгуулсан | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дагуу Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2020 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийнэ. | | газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг | газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | | | гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Дүнг 1а/1496 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний биелэлтэд эхний 6 сарын байдлаар явцын хяналт-шинжилгээ хийж, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний дундаж хувь 68.2 байна.<br>ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр, үнэлгээний танилцуулгыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 2021 оны 1а/5924 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| 161. | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний дүн | Жил бүр үнэлгээ хийж Сангийн яаманд хүргүүлдэг | Үнэлгээний дүнг Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа 21 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар хийсэн үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Тайланг 1а/882 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100.0 |
| 162. | Эрүүл мэндийн байгууллагуудын | Дотоод аудитын 2021 оны үйл | Жил бүр Дотоод | Эрсдлийн үнэлгээнд | I улирал | ХШҮДАГ | Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | болон төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд эрсдлийн үнэлгээ хийнэ. | ажиллагааны төлөвлөгөө | аудитын үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулдаг | үндэслэн “Дотоод аудитын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” батлагдсан байна. | | | тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу төсөл, хөтөлбөр, Эрүүл мэндийн сайдын багцад 2020 онд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 131 төсөл, арга хэмжээ (шилжих 45 барилга, шинэ 28 барилга, их засвар 24 төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж 35 төсөл арга хэмжээ)-нд эрсдэлийн үнэлгээг хийсэн. Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн Дотоод аудитын 2021 оны төлөвлөгөөг Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. | |
| 163. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан “Дотоод аудитын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтыг гүйцэтгэнэ. | Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан | Жил бүр дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан гардаг | “Дотоод аудитын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” хэрэгжсэн байна. | I-IV улирал | ХШҮДАГ | Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан “Дотоод аудитын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд төсөл хөтөлбөрийн дотоод аудитын 9 ажил, хөрөнгө оруулалтын дотоод аудитын 9 ажил, санхүүгийн хяналт, шалгалтын 9 ажил, нийт 27 ажил тусгагдсан байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 22 ажил, хэрэгжээгүй 5 ажил байна.<br>Дотоод аудитын 2021 оны төлөвлөгөө 81.5 хувьтай биелсэн байна. Төлөвлөгөөний биелэлтийг чиглэл тус бүрээр харуулбал:<br>1. Төсөл, хөтөлбөрийн дотоод аудитын чиглэлээр:<br>Төсөл хөтөлбөрийн 9 дотоод аудитын ажил төлөвлөснөөс 100% хийгдсэн. Үүнд: “Монгол Улсад шугман хурдасгуурт суурилсан дэвшилтэт технологи нэвтрүүлснээр хорт хавдрын туяа | 90.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмчилгээний чанарыг сайжруулах” MON/6020 төсөл, “Стереотактик туяа эмчилгээний аргыг шинээр нэвтрүүлэх замаар Монгол Улс дахь нийтлэг хорт хавдрын туяа эмчилгээний чанарыг сайжруулах нь” MON/6021 төсөл, ГССҮТ-д Цахим эрүүл мэнд төслөөр нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалт, “Түлэнхийн төв барих төсөл”, “ЭМСХХ-5” төслийн Хөвсгөл АНЭ-ийн АҮТТ хэрэгжилт, “Баруун БОЭТ-ийг бэхжүүлэх” төсөл, “Цахим эрүүл мэнд” төсөл, Глобаль сангийн ДОХ/Сүрьеэгийн төслийн хэрэгжилт, “Монгол Улсад COVID-19-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслүүдэд батлагдсан удирдамжийн дагуу дотоод аудитыг гүйцэтгэсэн.<br>2. Хөрөнгө оруулалтын дотоод аудитын чиглэлээр:<br>Хөрөнгө оруулалтын 9 дотоод аудитын ажил төлөвлөснөөс 100% хийгдсэн. Үүнд: Геронтологийн төвийн барилга, дэд бүтэц, СХД-ийн ЭМТөвийн барилгын өргөтгөл, Архангай, Булган сумын ЭМТ-ийн барилгын их засвар, Хэнтий, Дэлгэрхаан сумын ЭМТ-ийн барилгын их засвар, Багануур дүүргийн ЭМТ-ийн томографийн аппарат, Дархан-уул, Дархан сум, 10, 11, 12, 13, 14, 15, 16 | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаар багийн ӨЭМТ-ийн тоног төхөөрөмж, ХСҮТ-ийн тоног төхөөрөмж, Өвөрхангай аймаг дахь БОЭТ-ийн 2020 оны худалдан авах ажиллагаа, Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу дотоод аудитыг гүйцэтгэсэн.<br>3. Санхүүгийн хяналт шалгалтын талаар:<br>Санхүүгийн хяналт, шалгалтын 9 ажил төлөвлөснөөс 4 ажил хийгдэж, 5 ажил хийгдээгүй тул биелэлт 55,6%-тай байна. ГССҮТ, ЗӨСҮТ, ЭМСХХ-4 төслийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, ЭМДЕГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудитыг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Харин ЭХЭМҮТ, Дундговь аймгийн ЭМГ, Дорнод аймаг дахь БОЭТ, Ховд аймаг дахь БОЭТ, ЭМСХХ-4 төслийн 2020 оны үйл ажиллагааны санхүүгийн хяналт шалгалт хийгдээгүй байна. | |
| 164. | Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр “2020 онд Коронавируст халдварын үед улсын төсөв болон бусад эх үүсвэрээр эрүүл мэндийн салбарт хүлээн авсан хандив, | Санхүүгийн хяналт шалгалтын тайлан | - | Санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг хугацаанд нь хийсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн сайдын удирдамжаар “2020 онд Коронавируст халдварын үед улсын төсөв болон бусад эх үүсвэрээр салбарт хүлээн авсан хандив, тусламжийн зарцуулалт, ажилтнуудад олгосон илүү цагийн цалин хөлсний байдалд тусгайлсан санхүүгийн хяналт шалгалт хийсэн. Шалгалтын дүн тайланг ЭМЯ-ны удирдлагуудад | 100.0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2021 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тусламжийн зарцуулалт, ажилтнуудад олгосон илүү цагийн байдалд тусгайлсан СХШ хийнэ. | | | | | | танилцуулсан. | |
| 165. | Эрүүл мэндийн яамны төсвийн шууд захирагчийн шийдвэрээр “2020 онд Коронавируст халдварын үед ЭМЯ-нд төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр ирүүлсэн хандив тусламж, хөрөнгө оруулалтын зарцуулалтад тусгайлсан дотоод аудит” хийнэ. | Дотоод аудитын тайлан | - | Дотоод аудитын үйл ажиллагааг хугацаанд нь хийсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн яамны төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийн хүрээнд “төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” чиглэлийг хэрэгжүүлэхээр Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу “2020 онд коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед Эрүүл мэндийн яаманд хүлээн авсан гадаадын болон олон улсын байгууллагын хандив тусламжийн зарцуулалт”-д дотоод аудитыг хийж, тайланг боловсруулан удирдлагад танилцуулсан. | 100.0 |
| **Хэрэгжилтийн дундаж хувь** | | | | | | | | **80,1** |

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ШИЙДВЭР

2022 оны 1 дүгээр сарын 13

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 80.1 хувийн үнэлгээтэй гэж үзэх

2. Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээний дүнгээр хэрэгжээгүй буюу хэрэгжилт хангалтгүй байгаа үйл ажиллагааг эрчимжүүлэх, албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хяналт тавьж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт даалгах

3. Эрүүл мэндийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээний дүнгээр хэрэгжээгүй буюу хэрэгжилт хангалтгүй байгаа үйл ажиллагааг хариуцсан албан хаагчдад хууль, журмын дагуу хариуцлага тооцохыг ТЗУГ-т даалгах

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ц.ЭРДЭМБИЛЭГ